


Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлт

Хэвлэл мэдээллийн хөгжлийн үнэлгээ

Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн хөтөлбөрийн (IPDC)

Засгийн газар хоорондын зөвлөл 2008 оны 3 дугаар сарын

26-28-ний өдрүүдэд зохион байгуулагдсан 26-р чуулганаар батлав.



Талархал

ЮНЕСКО нь ноён Эндрю Пудеффаттад Хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлт боловсруулахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулсанд гүн талархал илэрхийлж байна. Тус байгууллагаас мөн Хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж дуусган, Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн Олон улсын хөтөлбөрийн Засгийн газар хоорондын зөвлөлд танилцуулахад оролцсон олон улсын шинжээчдийн бүлгийн бүх гишүүдэд мөн талархснаа илэрхийлэхийг хүсч байна.

Анхны хэвлэлтийг ЮНЕСКО-гоос 2008 онд эрхлэн гаргасан.

Мэдээлэл, харилцаа холбооны салбар 1, rue Miollis 75732 Paris Cedex 15

Typeset by Baseline Arts Ltd, Oxford Printed by UNESCO, Paris

Хоёр дахь хэвлэл 2010 онд хэвлэгдсэн

Бүртгэлийн дугаар: CI/COM/2008/PI/3

АГУУЛГА

Өмнөтгөл

Танилцуулга

Хэвлэл мэдээлэл, ардчилал ба хөгжил

Энэхүү баримт бичгийн тухай

Тусгай арга зүй

Шалгуур үзүүлэлтийг жендерийн мэдрэмжтэй, ядуучуудыг дэмждэг болгох нь

Шалгуур үзүүлэлтийн ангиллууд

Ангиллуудын тайлбар

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ангилал 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг хангаж буй зохицуулалтын тогтолцоо

- A. Эрх зүй, улс төрийн хүрээ
- B. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын тогтолцоо
- C. Гүтгэлэг, нэр төртэй холбоотой хууль ба сэтгүүлчдэд тавьж буй эрх зүйн бусад хязгаарлалт
- D. Цензур

Ангилал 2. Хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдал, салбарын эдийн засгийн түвшин, өмчлөлийн ил тод байдал

- A. Хэвлэл мэдээллийн төвлөрөл
- B. Олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээллийн олон талт холимог бүтэц
- C. Тусгай зөвшөөрөл, давтамжийн хуваарилалт
- D. Татвар, бизнесийн зохицуулалт
- E. Зар сурталчилгаа

Ангилал 3. Хэвлэл мэдээлэл ардчилсан яриа хэлэлцүүлгийн талбар болох нь

- A. Хэвлэл мэдээлэл нийгмийн олон талт байдлыг илэрхийлнэ
- B. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн загвар
- C. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт
- D. Шударга байх, тал тохой татахгүй байх шаардлагууд
- E. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олон нийт итгэдэг эсэх
- F. Сэтгүүлчдийн аюулгүй байдал

Ангилал 4. Мэргэжлийн чадавхи эзэмшүүлэх ба илэрхийлэх эрх чөлөө, олон ургальч, олон талт байдлыг хөхиүлэн дэмжихэд тусламж үзүүлдэг байгууллагууд

- A. Хэвлэл мэдээллийн мэргэжлийн сургалт бий эсэх
- B. Хэвлэл мэдээллийн академик боловсрол олгож буй эсэх
- C. Үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн эвлэл холбоод буй эсэх
- D. Иргэний нийгмийн байгууллагууд оролцдог

Ангилал 5. Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжихүйц хангалттай дэд бүтцийн чадавхи

- A. Хэвлэл мэдээлэл техникийн нөөц боломжтой, түүний ашиглалт
- B. Сонин хэвлэл, өргөн нэвтрүүлэг, мэдээлэл харилцааны технологи нэвтэрсэн байдал

Ном зүй

ӨМНӨТГӨЛ

Ардчиллын бүтээн байгуулалт, түүний тогтвортой байдалд хэвлэл мэдээллийн оруулах хувь нэмэр, түүний хүний хөгжлийн хурдасгагч байх чадвар нь ЮНЕСКО-гийн хэвлэл мэдээллийг хөгжүүлэх хүчин чармайлтын үндэслэл юм. Чөлөөт, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээлэл иргэдэд мэдээлжсэн сонголт хийх, ардчиллын үйл хэрэгт идэвхтэй оролцох боломж бүхий мэдээллээр хүчирхэгжүүлдэг. Мөн шийдвэр гаргагч, иргэдийн хоорондын харилцан ярианд нөлөөлж, эрх мэдлээ урвуулан ашиглахыг илчлэх замаар ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд дөхөм болдог. Хэвлэл мэдээлэл нь иргэдэд өрнөж буй асуудал, үйл явдал, тэргүүн зэргийн ач холбогдолтой мэдээ, мэдээлэл, бодлого, шийдвэр танилцуулах, сонголт хийх зэрэг асуудлыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хэдий тийм ч хэвлэл мэдээллийн ардчилсан чадварыг бүрэн хэмжээгээр ашиглан, түүний хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд ямар нөхцөл бүрдүүлэх вэ? Үүнтэй холбоотой ямар бодлого боловсруулах шаардлагатай вэ? Хэвлэл мэдээллийн хөгжлийн дэмжлэгийг яаж чиглүүлэх вэ?

ЮНЕСКО-гийн Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн хөтөлбөр (IPDC) нь эдгээр асуудлыг харгалзан үндэсний хэвлэл мэдээллийн төрх байдлыг үнэлэх иж бүрдэл шалгуур үзүүлэлтийг боловсруулах санаачилга гаргасан юм. Хоёр жилийн турш дэлхийн олон шинжээч, мэргэжилтэн, байгууллага оролцуулсан хэлэлцүүлэг явуулсны үр дүнд, иж бүрдэл шалгуурыг боловсруулж дууссан бөгөөд IPDC-ийн Засгийн газар хоорондын зөвлөл 2008 оны 26-р хурлаараа баталсан.

Виндхукийн тунхаглал болон Алматы, Сантьяго, Сана, Софид батлагдсан Хараат бус олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжих бүс нутгийн тунхаглалууд шалгуур үзүүлэлт болосвруулах онолын үндэс болсон. ЮНЕСКО хэвлэл мэдээллийн хөгжил нь нэгдмэл хандлага шаарддаг гэдгийг ухамсарлан шалгуур үзүүлэлтүүдэд хэвлэл мэдээллийн салбарыг тал бүрээс авч үзэхийг чармайсан. Үнэхээр, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл хөгжих орчин бий болгох нь чухал ч, мэдээллийн эх сурвалжийн олон ургальч, олон талт байдлыг хангах, нийгмийн бүхий л салбарт оролцох, сэтгүүлчдийн мэргэжлийн өндөр стандарт, шаардлага хангасан дэд бүтэж, техникийн нөөц бололцоо хэвлэл мэдээлэлд нь мөн чухал. Эдгээр асуудлын талаар уг номонд буй 5 бүлэгт нарийвчлан авч үзэв.

Дэлхийн 9 хэл дээр эрхлэн гаргасан Хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлт нь (ХМШҮ) 2008 оноос хойш НҮБ-ын агентлаг, хөгжлийн түнш, засгийн газар хоорондын байгууллага, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагын дунд өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн. ХМШҮ боловсруулж эхэлсэн эсвэл дуусгасан улс орнуудаас Бутан, Бразил, Хорват, Эквадор, Мальдив, Мавритан, Мозамбик, Непал зэрэг хэд хэдэн орнууд ашиглалтынх нь талаар санаа зовох нь нэмэгдсээр байна. НҮБ нь ХМШҮ-ийг харилцаа холбооны хөгжил болон сайн засаглалын хүрэн дэх нийтлэг хандлагыг бүрдүүлэх үндэс болгон ашиглаж байна. ЮНЕСКО нь Статистикийн

хүрээлэнтэй (UIS) хамтран улс орнуудын бэлэн буй өгөдлийн цоорхойг нөхөхөд туслахуйц олон улсын хэм хэмжээнд нийцсэн хэвлэл мэдээллийн шинэ багц тоо баримт боловсруулж, хэрэглэх тал дээр ажиллаж байна.

Тус хэвлэлийг авсаархан, хэрэглэгчдэд таатай хэлбэрээр дахин хэвлэх нь энэ эрч хүчээрээ өвөрмөц хэрэглүүрийг ашиглахад оролцогч талуудыг өргөнөөр татан оролцуулахад хөхиүлэн дэмжиж, олон нийтийг мэдээлэл, үзэл санаа илэрхийлэх, эрэн хайх, хүлээн авах, хуваалцах язгуур эрхээ эдлэхэд шаардагдах нөхцөл байдлыг дээшлүүлнэ хэмээн бид итгэж байна.

Янис Карклинс

*ЮНЕСКО-гийн Мэдээлэл, харилцаа холбооны асуудал
хариуцсан Ерөнхий захирлын туслах*

ТАНИЛЦУУЛГА

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, АРДЧИЛАЛ БА ХӨГЖИЛ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үндсэн элемент бөгөөд улс төрийн нам байгуулах, улс төрийн үзэл бодлоо хуваалцах, нийтийн албан хаагчийн аливаа үйлдэлд эргэлзэж буйгаа мэдэгдэх зэрэг ардчилсан эрх чөлөөг дэмжигч үндэс суурь хэмээн тооцогддог.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдлэхэд чухал үүрэгтэй. Учир нь уг эрх үр дүнтэй хэрэгжихэд нөлөөлөх нийтийн талбар бий болгодог. Хэвлэл мэдээлэл ардчилсан хэлэлцүүлгийн талбар хэмээх үзэл санаа нь олон талт давхардсан функцийг агуулна. Энэ утгаараа хэвлэл мэдээлэл нь мэдээ, олон нийтийн мэдээлэл дамжуулдаг бүхий л сувгийг хамруулдаг. Хэвлэл мэдээлэл нь:¹

- иргэд хоорондоо харилцах боломж бүхий мэдээлэл, боловсролын суваг
- түүх, үзэл санаа, мэдээлэл түгээдэг
- удирдагч, удирдуулагчдын хооронд, мөн өрсөлдөж буй хувийн байгууллагуудын дунд “мэдээллийн тэгш хэмгүй байдал” (Islam 2002:1) -ыг засч залруулдаг
- нийгмийн төрөл бүрийн давхаргын төлөөлөгчдийн мэдээлжсэн мэтгэлцээнийг зохион байгуулж, маргааныг ардчилсан зарчмаар шийдвэрлэдэг
- нийгэм өөрийгөө танин мэдэж, хамтач ухамсар бүрэлдүүлэн, үнэт зүйлс, зан заншил, уламжлалын тухай ойлголт төлөвшүүлдэг
- үндэстэн доторх, тэдгээрийн хоорондын соёлын илэрхийлэл, түүний хэлхээ холбооны хэрэгсэл болдог
- нийгмийн ил тод байдлыг дэмжин, эрх мэдэлтнүүдийн авлига, буруу удирдлага, гэм бурууг илчлэх замаар олон нийтийн шүүмжлэлийг хөхиүлэн дэмжих төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг
- төрийн ил тод байдлыг хангах, авлига, буруу удирдлага, гэм бурууг илчлэх аргаар эрх мэдэлтнүүдэд хяналт тавихад нөлөөлөх төр засгийн үйл ажиллагааны “хоточ нохой”-н үүрэг гүйцэтгэдэг
- эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлдэг
- ардчилсан үйл явцын чухал зохицуулагч ба чөлөөт, шударга сонгуулийг баталгаажуулдаг
- олон ургальч үнэт зүйлсийг дээдэлдэг бөгөөд бүрэн эрхт хамгаалагч, нийгмийн оролцогч болдог.

Зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ньтодорхой хүрээнийхний эрх мэдэл бэхжүүлэхэд үйлчлэх, шүүмжлэгч буюу нийгмээс тусгаардагдсан давхаргыг үл

¹ What follows is a synthesis of various reports on the media and democratic development, including: Article 19 (undated); Islam (2002); Global Forum for Media Development (2006); Norris and Zinnbauer (2002); UNESCO-CPHS (2006).

ойшоосноос үүдэн нийгмийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэхэд нөлөөлдөг. Түүгээр ч үл барам хэвлэл мэдээлэл нь зөрчилдөөн, нийгмийн хагаралдааныг өдөөж болно.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сайн засаглал, хүний эрхийн чиглэлээр ажиллагчдын гол асуудал нь бүхнийг хамарсан эдгээр зорилгыг биелүүлэхэд хувь нэмэр болохуйц хэвлэл мэдээллийн тогтолцоо, практик бий болгох. Ялангуяа, хэвлэл мэдээллийн тогтолцоо нь дарамт шахалт, авлига эсвэл дайн, буурай хөгжлөөс улбаалж гажсан буюу уналтад орсон нь ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улс орнуудын хувьд хурцадмал асуудал мөн.

Орчин үеийн харилцааны хэрэгслүүд нэгдэх явдал нэмэгдэж буй тул ардчилал тогтсон улс орнуудад хүртэл хэвлэл мэдээллийн үүрэг бодит асуудал болж байна. Тоон харилцааны сүлжээнд холбогдох хямд төсөр электрон хэрэгслүүд нь иргэдэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх шинэ боломжууд нээж байна. Гэсэн хэдий ч, эдгээр харилцаа холбооны хувьсгалын ололт амжилт нь улсуудын дотор болон тэдний хооронд тэгш бус, шинэ харилцаа холбооны талбар хавчин дарангуйлах төдийгүй эрх чөлөөнд хөтлөх чадвартай.

Хараат бус сэтгүүл зүй нь сайн засаглалыг бэхжүүлж, хүний хөгжлийг дэмжихэд зайлшгүй боловч хангалттай бус арга хэрэгсэл гэдгийг олон тайлбарлагч нотолдог. Тэд дараахь 2 нөхцөл бүрдүүлсний үндсэн дээр уг зорилгод хүрнэ гэсэн санал дэвшүүлжээ. Үүнд:

- өргөн олны мэдээлэл харилцааны сувгууд нь тогтсон ашиг сонирхлоос чөлөөт, хараат бус нийгэмд
- эдгээр хэвлэл мэдээллийг өргөнөөр хүртэх боломжтой нөхцөлд

Хэвлэл мэдээллийн хөгжлийг хэмжих аливаа оролдлого нь *хараат бус байдал* ба *хүртээмж* гэсэн 2 ойлголтыг хамарч байгааг үүгээр харуулж байна. Энд, хэвлэл мэдээлэлд хязгаарлалт тавихгүй гэдгээс гадна нийгмийн бүх салбарынхан, ялангуяа нийгмээс тусгаарлагдсан давхарга мэдээлэл авч, дуу хоолойгоо хүргэхийн тулд хэвлэл мэдээлэл хүртээмжтэй байна гэсэн утга агуулна.

Хэвлэл мэдээллийн хүртээмж хязгаарлагдах буюу байхгүй байх нь ядуурал, дорой боловсролын илрэл юм. Энэ нь мөн хэлний мэдлэг, нас хүйс, үндэс угсаа эсвэл хот хөдөөгийн ялгаанаас үүдэлтэй байж болно. Үүнээс гадна, мэдээлэл түгээх, хэвлэл мэдээллийн тухай ойлголт мэдлэг дээшлүүлэх шаардлагатай.

Энэхүү дүн шинжилгээний үр дүн нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, **олон ургальч, олон талт** байдлаар тодорхойлогдож, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хязгаарлалтыг ардчилсан нийгэмд нийцэхүйцээр нарийвчлан тодорхойлсон хууль тогтоомжтой, эдийн засгийн эрх тэгш оролцоог хангасан эрх зүйн орчин бүхий хэвлэл мэдээллийн орчин

бүрдүүлэхэд төр засгийн оролцоо шаардлагатайг харуулж байна. Үүнд олон нийтийн, хүйн, хувийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

Хүний нөөцөд хөрөнгө оруулахын зэрэгцээ академик, мэргэжлийн сургалт, мэргэжлийн эвлэл холбоодын хөгжлөөр дамжуулан хэвлэл мэдээллийн салбарын сэтгүүлч, удирдлагын аль алиных нь *мэргэжлийн чадавхи дээшлүүлэх* нь нэн чухал.

Дэд бүтцийн чадавхи мөн шийдвэрлэх үүрэгтэй. Хэвлэл мэдээллийн олон талт орчинг хөхиүлэн дэмжих нь харилцаа холбооны хэрэгсэл, өргөн нэвтрүүлэг хүлээн авах, цахилгаан хэрэгслийн хангамж, утас, интернетийн хүртээмж зэрэгт хөрөнгө оруулахыг шаардана.

Дүн шинжилгээний эдгээр үзүүлэлт дотор зөрчилдөөн, өөр саналууд гарах боломжтой. Жишээлбэл, Мали улсад (Norris and Zinnbauer 2002:12) байдаг шиг бага хүчин чадалтай техник нь эрх зүй, бодлогын зэрэг тогтолцоотой зэрэгцэн оршиж болно. Бусад улс оронд, хэвлэл мэдээлэл нь улс төрийн тааламжгүй орчинд хүртэл нээлттэй орчин бий болгоно.

Эцэст нь, хүний хөгжилд оруулах хэвлэл мэдээллийн хувь нэмэрт аливаа дүн шинжилгээ хийхдээ харилцаа холбооны талбарын хурдацтай өөрчлөлтийг харгалзан үзэх шаардлагатай. Дэлхийн зарим бүс нутаг дахь шинэ технологийн (интернет, SMS, гар утас г.м.) толгой эргэм хөгжил нь ардчиллын үйл явцад нааштай боломж олгож байгаа боловч задрал бутрал, хэвлэл мэдээллийн хязгаарлагдмал сувгаар олон хүнд мэдээлэл дамжуулах боломж хомс зэрэг бэрхшээл учирч болно.

Үнэлгээний арга хэрэгслийг үр дүнтэй болгохын тулд харилцаа холбооны эдгээр шинэ талбарыг харгалзан үзэж, хэвлэл мэдээллийн салбарын уян хатан, дасан зохицох чанартай хослуулах нь зүйтэй.

ЭНЭХҮҮ БАРИМТ БИЧГИЙН ТУХАЙ

НҮБ-ын тогтолцооны хүрээнд, ЮНЕСКО нь хэвлэл мэдээллийн хөгжлийг хөхиүлэн дэмжих мандаттай. ЮНЕСКО-гийн дүрмэнд “үгээр, дүрсээр илэрхийлэх чөлөөт санаа бодлыг хөхиүлэн дэмжих” хэмээн тухайн байгууллагын чиг үүргийг заасан байдаг. ЮНЕСКО-гийн 1989 онд батлагдсан Харилцаа, холбооны шинэ стратегид Мэдээлэл, харилцаа холбооны хүрээн дэх байгууллагын зорилтуудыг “Мэдээллийн чөлөөт урсгалыг үндэсний болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжих, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахгүйгээр өргөн хүрээний, тэнцвэржүүлсэн мэдээлэл түгээх, харилцаа холбооны үйл явц дах оролцоог нь нэмэгдүүлэхийн тулд хөгжиж буй орнуудад харилцаа, холбооны чадавхи бий болгох” гэж тодорхойлжээ. Мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн хөтөлбөр (IPDC)-ийн зорилго нь “хөгжиж буй болон шилжилтийн үеийн улс орны цахим хэвлэл мэдээлэл, сонин хэвлэлийн чадвар дээшлүүлэх замаар бүх нийтийн

мэдээллийн хүртээмж, мэдлэг бэхжүүлж, тэдгээрийг түгээх аргаар тогтвортой хөгжил, ардчилал, сайн засаглалд хувь нэмэр оруулах”² юм.

Энэхүү баримт бичгийг IPDC-ийн тэргүүлэх салбарын дагуу хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох дараахь зорилгоор боловсруулав. Үүнд:

- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн олон ургальч байдлыг хөхиүлэн дэмжих
- хүйн хэвлэл мэдээллийг хөгжүүлэх
- хүний нөөцийг хөгжүүлэх (хэвлэл мэдээллийн ажилтнууд, нийгмийн байгууллын чадавхи бий болгох)

Уг баримт бичгийг ЮНЕСКО-гийн Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжих талаарх 5 тунхаглалын (Виндхукийн Тунхаглал, мөн Алматы, Софи, Сантьяго, Сана³-д болсон бүсийн хурлуудаар батлагдсан тунхаглалууд) хүрээнд боловсруулж, тус байгууллагын Ерөнхий бага хурлаар баталсан. Уг тунхаглалууд нь үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ирсэн бүхнийг хамарсан зарчмуудыг санал болгосон юм.

Эдгээр тунхаглалын мөн чанарт, ЮНЕСКО нь хэвлэл мэдээлэлд цаашдын зохицуулалт хийх бус харин хараат бус сэтгүүл зүй хөгжих орчин бүрдүүлэхэд бүхий л анхаарлаа хандуулахыг уриалсан байна. Сэтгүүлчдийг сурвалжлага хийх чадварт сургах нь чухал ач холбогдолтой боловч тэдний өөрсдийн мэргэжлийн ур чадвараа практикт ашиглахгүй, мэргэжлийн үүргээ гүйцэтгэх таатай орчин бүрдээгүй нөхцөлд үр дүн гарахгүй.

Уг баримт бичиг нь тухайн орны хэвлэл мэдээллийн хөгжилд дүн шинжилгээ хийхэд ашиглах шалгуур үзүүлэлтийн 5 гол ангилал санал болгоно. Ангилал бүр өргөн хүрээний багц шалгуур үзүүлэлтийг агуулсан бүрэлдэхүүнтэй. Араас нь нотлох аргууд ба өгөгдлийн эх сурвалжийг заасан болно.

Эдгээр шалгуур үзүүлэлт нь урт хугацааны турш дүн шинжилгээ хийх эсвэл улс орнуудыг хооронд харьцуулах арга хэрэгсэл биш бөгөөд хэвлэл мэдээллийн байдалд үнэлгээ хийдэг, түүний хөгжлийн хөтөлбөрийн үр нөлөөг хэмждэг оролцогч талуудад зориулсан дүн шинжилгээний хэрэгсэл юм. Шалгуур үзүүлэлт нь зааварчилгаа бус оношилгооны хэрэглүүр тул аливаа нөхцөл шаардлага тулгадаггүй бөгөөд хэвлэл мэдээллийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор боловсруулсан.

² Resolution no. 32 C/75, adopted by UNESCO at its 32nd General Conference in October 2003, available at http://portal.unesco.org/ci/en/files/20810/11351773301ipdc_statutes_amendments_en.pdf/ipdc_statutes_amendments_en.pdf

³ (<http://unesdoc.unesco.org/images/0010/001091/109197eo.pdf>), contains a copy of a UNESCO publication containing the basic texts in communication that have been adopted between 1989 and 1995. The Sofia declaration is at <http://unesdoc.unesco.org/images/0010/001095/109559eo.pdf>. The Sana'a final declaration is at http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=1622&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

Төгсгөлд нь, үндсэн зорилтот хэрэглэгчид болох орон нутгийн хэмжээнд хэвлэл мэдээллийг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдээр шалгагдаж, тухайн орчинд тохируулах “амьд” баримт бичиг гэдгийг тайлбарлах нь зүйтэй.

АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Энэхүү баримт бичиг нь олон төрлийн арга зүй⁴ ашиглан боловсруулсан хэвлэл мэдээллийн хөгжлийг хэмжих санаачилгуудын өмнөх дүн шинжилгээн дээр тулгуурласан. Баримт бичиг нь үндэсний нөхцөл байдалд тохируулж болохуйц “хэрэглүүр”-ийг санал болгон, шалгуур үзүүлэлтийн тогтсон арга зүйн хандлага зааварладаггүй.

Хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг сонгоход ерөнхийд нь анхаарах зарим зүйлийг харгалзан үзсэн:

- тоон хэмжүүр боломжийн хэрээр ашиглах
- хэмжүүрийн өгөгдөл нь итгэлтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн тохиолдолд шалгуур үзүүлэлтийг сонгох
- шалгуур үзүүлэлтийг жендер эсвэл хүн ам зүйн бусад онцлогоор салгах
- шалгуур үзүүлэлтийг нэг гол асуудалд нэгэн зэрэг хандахаар хуваасан байхад анхаарах
- хэмжүүрийн өгөгдлийг бүрдүүлэх зардал, цаг хугацаатай холбоотой практик үр дагаврыг харгалзан үзэх

Гэсэн хэдий ч, үүнд анхааруулга тайлбар хийх шаардлагатай. Бүх нийтийн хэмжээнд өгөгдөл хангалтгүй байгааг анхаарах нь зүйтэй бөгөөд баримт бичиг нь оношилгооны хэрэглүүрийн хувьд дангаараа шаардлагатай мэдээллээр хангахгүй. Цаашид санал болгож буй шалгуур үзүүлэлтийг хэмжихэд шаардагдах өгөгдлийг тодорхойлбол зохино. Дотоодын найдвартай мэдээллийн сан бүрдүүлэхийн тулд эрүүл мэнд, ХДХВ-ын мониторингийн ажиглалтын төв гэх мэт бусад салбарынхны туршлагаас суралцах шаардлагатай.

Бүрдүүлсэн мэдээллийн сан нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг ба мэдээлэл цаг хугацаагаар шалгарах нь найдвартай байдалд нөлөөлдөг. Хуучирсан мэдээллийг ашиглахдаа сайтар тунгаан бодох, ялангуяа харилцаа холбооны уян хатан шинжийг харгалзах хэрэгтэй. Багагүй ач холбогдол бүхий боловч хэмжих боломжоор бага шалгуур үзүүлэлтийн оронд илүү үндэслэл бүхий нотлох аргууд бүхий шалгуур үзүүлэлтийг өөрийн эрхгүй илүүд үзэх эрсдэл бий.

Эцэст нь, тоон бөгөөд хэмжиж болохуйц үзүүлэлтүүдийг боломжоороо эрж хайх

⁴ UNESCO (2007), *Defining Indicators of Media Development – Background Paper*, http://portal.unesco.org/ci/en/files/24288/11743196661media_development_indicators_background_paper.pdf
[media_development_indicators_background_paper.pdf](http://portal.unesco.org/ci/en/files/24288/11743196661media_development_indicators_background_paper.pdf)

эрмэлзлийг үл харгалзан эдгээр шалгуур үзүүлэлтийн ихэнх нь чанарын эсвэл субъектив үнэлгээнд үндэслэсэн. Хэвлэл мэдээллийн аливаа цогц үнэлгээ нь дээрх байдалтай зайлшгүй тулгардаг бөгөөд уг баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдэд үүнийг хүлээн зөвшөөрсөн. Ингэхдээ, субъектив эсвэл тоон шалгуур үзүүлэлт нь тунгалаг байх бөгөөд хэрхэн боловсруулагдсан талаар тайлбарлагдсан байх нь чухал.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ЖЕНДЕРИЙН МЭДРЭМЖТЭЙ, ЯДУУЧУУДЫГ ДЭМЖДЭГ БОЛГОХ

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн мэдээлэл авах эрхийн хөтөлбөрийн нөлөөлөл хэмжих хөтөчид («Guide to Measuring the Impact of Right to Information Programmes») мэдээлэл авах эрхийн шалгуур үзүүлэлт жендерийн төлөв тусгах, ядуу давхаргын эрх ашигт нийцүүлэх үндсэн санааг тусгасан (UNDP 2006:11-12). Уг хөтөчид тэмдэглэхдээ:

- эрэгтэй, эмэгтэй хүмүүс хуулиар албан ёсны тэгш эрхтэй байх нь бодит эрх тэгш байдлын ялгааг нуун дарагдуулж болно
- иргэдийн уламжлалт эрхэнд зохицсон мэдээллийн тогтолцоо нь нийгмийн хүрээ эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал нийгэм дэх тэднийг гадуурхах боломжтой
- хяналт шинжилгээний тогтолцоог боловсруулах, үнэлгээ хийхээс эхлээд эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэгтгэх
- шалгуур үзүүлэлтийг ядуучуудад зориулахын тулд ижил төстэй санаа баримтлах шаардлагатай, ядуу хүмүүс, тэр тусмаа мэдээлэл харилцааны тогтолцоо хэрэгждэггүй, бичиг үсэг үл мэдэх явдал газар авсан хөдөө нутагт мэдээллийн хүртээмж хэр байгаад илүү анхаарал хандуулах шаардлагатай

Эдгээр ойлголт нь хэвлэл мэдээллийн хөгжлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох аливаа санаачилгад тусгагдана. Бичиг үсгийн боловсролын түвшин багатай хөдөө нутгийн ардчилсан хөгжилд сонин хэвлэл ач холбогдол багатай байх жишээтэй.

Жендерийн тэгш бус байдлыг ухамсарлах явдал мөн хэвлэл мэдээллийн өмчлөлд дэлгэрнэ.⁵ Зарим санаачилгын ачаар жендер болоод эдийн засагийн тэгш бус байдлыг ухамсарлах нь МХТ-ийн салбарт үр ашигтайгаар түгнэ.⁶

⁵ UNESCO has promoted the idea of community radio stations owned and managed by women, such as the Women's Media Centre in Cambodia (www.wmc-cambodia.org).

⁶ The South African-based NGO bridges.org assesses existing measurement tools according to their sensitivity to gender and pro-poor indicators (see www.bridges.org).

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АНГИЛЛУУД

Энэ бүлэгт илүү нарийвчлан боловсруулсан шалгуур үзүүлэлтийг багтаасан.

Шалгуур үзүүлэлт сонгохдоо хэвлэл мэдээлэл сайн засаглал, ардчилсан хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулах, мөн тэдгээрийн үр өгөөжийг хүртэх талаар зөвшилцөлд хүрсэн санаанууд дээр тулгуурлахыг зорьсон.

Санал болгож буй үйл ажиллагаа нь салангид, тусдаа хэвлэл мэдээллийн байгууллагыг⁷ бус хэвлэл мэдээллийг дотоодын хэмжээнд үнэлгээ хийхэд чиглэгдсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Уг бүлэгт хэрэглүүрийн хандлагын дагуу тодорхой эрэлт хэрэгцээнд тулгуурлан сонголт хийж болох шалгуур үзүүлэлтийн жагсаалт оруулсан.

Энэ жагсаалт нь зааварчилгаа өгөх бус хэвлэл мэдээллийн тухайн орны нөхцөл байдал дахь хөгжлийн санаачилгуудын хэрэгцээ шаардлагад нийцэхүйц үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулахыг зорино.

- Энэ баримт бичиг нь **хэвлэл мэдээллийн хөгжлийн 5 үндсэн ангилалд** хуваасан
- Ангилал бүрийг хэд хэдэн **асуудалд** хуваасан
- Ангилал бүрийн сэдэвт тохирох товч **агуулга ба гол асуудлыг** тоймолсон
- Ангилал бүрт туслах үзүүлэлтүүд бүхий **үндсэн үзүүлэлтийг** (толгойн үсгээр) оруулсан
- Шалгуур үзүүлэлт бүр төрөл бүрийн **нотлох аргуудтай**
- Ангилал бүр олон улсын хэмжээний **өгөгдлийн эх сурвалж** бүхий лавлахтай, уг хөтөч бүх мэдээллийг хамраагүй ч онлайн болон онлайн бус эх сурвалж руу чиглэгдсэн

Өгөгдлийн эх сурвалж үндэсний хэмжээний эсвэл бусад хэл дээрх төрөл бүрийн боломжит мэдээллийг агуулаагүй. Эдгээрийг тус баримт бичигт нэмж ашиглах шаардлагатай.

Хэвлэл мэдээллийн доорх 5 үндсэн ангилалд хуваана:

АНГИЛАЛ 1: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг хангаж буй зохицуулалтын тогтолцоо: мэдээлэлтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, олон улсын сайн туршлага дээр үндэслэн, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран боловсруулсан эрх зүй, бодлого,

⁷ The ISAS standards for broadcasters and the press provide individual media organisations with a robust methodology to improve their contribution to social development and to make their progress measurable and transparent.

зохицуулалтын тогтолцоотой.

АНГИЛАЛ 2: Хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдал, салбарын эдийн засгийн түвшин, өмчлөлийн ил тод байдал: төр засгаас олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээллийн хэт төвлөрлөөс сэргийлэх, олон ургальч үзэл, өмчлөл, агуулгын ил тод байдлыг баталгаажуулах замаар хэвлэл мэдээллийн салбарыг тууштай дэмждэг.

АНГИЛАЛ 3: Хэвлэл мэдээлэл ардчилсан яриа хэлэлцүүлгийн талбар болох нь: хэвлэл мэдээлэл нь өөрийн зохицуулалтыг хангаж, сэтгүүлчийн мэргэжлийг дээдэлсэн орчинд үйл ажиллагаа явуулан, нийгмийн, тэр дундаа нийгмээс тусгаарлагдсан давхаргын олон талт үзэл бодол, ашиг сонирхлыг тусган төлөөлдөг. Нийгэмд мэдээлэл, хэвлэл мэдээллийн талаар өргөн ойлголттой.

АНГИЛАЛ 4: Мэргэжлийн чадавхи эзэмшүүлэх ба илэрхийлэх эрх чөлөө, олон ургальч, олон талт байдлыг хөхиүлэн дэмжихэд тусламж үзүүлдэг байгууллагууд : хэвлэл мэдээллийн бүх шатны ажилтнууд нь тусгай мэргэжлийн болон академик боловсрол олгох мэргэжлийн сургалтад хамрагдах боломжтой бөгөөд хэвлэл мэдээллийн салбарт мэргэжлийн эвлэл холбоо, иргэний нийгмийн байгууллага хяналт шинжилгээ хийж, дэмжлэг үзүүлдэг.

АНГИЛАЛ 5: Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжихүйц хангалттай дэд бүтцийн чадавхи: хэвлэл мэдээллийн салбар нь нийгмийн хүртээмжийн өндөр буюу өсөн нэмэгдэж буй хүрээ, орон нутгийн нөхцөл байдалд тохирохуйц мэдээ, мэдээлэл цуглуулах, түгээхдээ үр дүнтэй технологи ашигладаг байдлаар тодорхойлогдоно.

Ангилал 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг хангаж буй зохицуулалтын тогтолцоо

А. ЭРХ ЗҮЙ, УЛС ТӨРИЙН ХҮРЭЭ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хэвлэл мэдээлэлтэй холбоотой эрх зүй, бодлогын тогтолцооны бүтэц, бүрэлдэхүүн аль алийг авч үзүүштэй. Тухайн улс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэлтэй байх эрхийг зохицуулах эерэг хуультай боловч түүнийг хэрэгжүүлдэггүй эсвэл дагаж мөрддөггүй байх талтай. Тэдгээр хуулийн хэрэгжилтэд нууц буюу авлигатай холбоотой зан заншил, нийгмийн байгууллын эсэргүүцэл, засаг захиргааны нэгжийн техник, зохион байгуулалтын хомсдол зэрэг бэрхшээл учирч болно.

Түүнээс гадна, Үндсэн хуулийн баталгаажуулалт нь олон улсын гэрээний үүргүүд, төрийн нууц эсвэл гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн зэрэг хууль тогтоомжтой

зөрчилдөж болно. “Терроризмтэй тэмцэх дайн”-ы үр дүнд үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдөн, мэдээлэл хүртэхэд саад тотгор болох үндэсний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж, зохицуулалтууд үүссэн.

Иргэдийн ойлголтыг дээшлүүлж, тэднийг чадавхижуулах нь нэн чухал. Олон нийтийн эсвэл нийгмээс тусгаарлагдсан давхаргад мэдээлэл эрж хайхад хориг тавих эсвэл үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхэд саад учирч болно. Хуулиудыг дагаад иргэдийн эрхээ ойлгох, нийтийн албан хаагчдыг үүрэг хариуцлагаа ухамсарлахад чиглэгдсэн системчилсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлэх шаардлагатай. Төрийн байгууллагууд нөөц бололцоондоо тулгуурлан өөрсдийн санаачилгаар болон иргэдийн хүсэлт шаардлагаар албаны мэдээлэл хуваалцах механизм бий болгох нь зүйтэй. Төр засгийн зүгээс иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийг төрийн бодлогыг хэвлэл мэдээлэл рүү чиглүүлэхэд оролцох боломжоор хангах ёстой.

Үл ялгаварлах зарчмыг нэн тэргүүнд баримтбал зохино. Жишээлбэл, мэдээлэлтэй байх эрх нь зөвхөн тодорхой эрх мэдэл бүхий бүлэгт бус нийгмийн бүх салбар, бүх хэвлэл мэдээллийн байгууллага, үүний дотор хүйн хэвлэл мэдээлэлд хэрэгжих ёстой.

Редакцийн хараат бус байдлын эрх зүйн хамгаалалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний гол үндэс юм. Редакциас гарах шийдвэрүүдийг хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн шалгуур болон олон нийтийн мэдэх эрх дээр үндэслэн, төр засаг, зохицуулагч байгууллага буюу хувийн байгууллагын нөлөөнөөс ангид гаргах ёстой. Сэтгүүлчид мөн эх сурвалжаа хамгаалах эрх зүйн үр дүнтэй хамгаалалттай байх шаардлагатай. (Ангилал 3 – F. Сэтгүүлчдийн аюулгүй байдал хэсгийг үзэх)

Улс оронд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан хууль тогтоомж, хуулийн төсөл байхгүй нөхцөлд олон улсын холбогдох стандартад нийцэх хэвлэл мэдээллийн талаар баримтлах төрийн тодорхой бодлого байх ёстой.

Зохицуулалтын аливаа тогтолцоо нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжсэн, түүнчлэн ёс зүйн код, хэвлэлийн консул болон хэвлэл мэдээллийн ажилтнууд өөрсдөө удирддаг хэм хэмжээ тогтоох байгууллагууд бүхий өөрийн зохицуулалтын механизмтай байна. Зохицуулалтын тогтолцоонд үүрэг гүйцэтгэх эдгээр асуудлууд нь Ангилал 3-д дэлгэрэнгүй орсон. Давтамжийн зурвас нь хязгаарлагдмал үед тэнцвэртэй байдлыг хангах гэх мэт олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн зарим зохицуулалт хийхийг зөвшөөрдөг өргөн нэвтрүүлэг болон санаа бодлоо илэрхийлэх хэрэгсэл гэж үздэг тул чөлөөт илэрхийллийн хэрэгсэл болох сонин хэвлэлийг хооронд нь ялгаж зааглах шаардлагатай.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛЖ, АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

дотоодын хууль тогтоомж, үндсэн хуулиар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан
олон улсын зохих гэрээний үүргүүдэд онцгой үл хамаарахгүйгээр гарын үсэг зурж, соёрхон баталсан
олон нийт чөлөөтэй илэрхийлэх эрхийнхээ тухай ойлголттой, түүнийгээ эдэлдэг бөгөөд уг эрх тодорхой хэрэгжихийг баталгаажуулсан хэрэглүүр, этгээд байдаг

Нотлох аргууд

- олон улсын стандартад нийцэж, олон улсын практикт хүлээн зөвшөөрөгдсөн чөлөөт илэрхийллийн эрхтэй холбоотой аливаа хууль тогтоомж, бодлого
- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар дотоодын хэвлэл мэдээлэлд гарсан мэдээ, нийтлэл
- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой хэргүүд
- давж заалдах тодорхой эрх бүхий хараат бус үйл ажиллагаа бүхий шүүхийн тогтолцооны нотолгоо

1.2. МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ ЭРХИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛЖ, АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

мэдээлэлтэй байх эрх дотоодын хууль тогтоомж, үндсэн хуулиар баталгаажсан олон улсын зохих гэрээнүүдэд онцгой үл хамаарахгүйгээр гарын үсэг зурж, соёрхон баталсан
олон нийт албан мэдээлэл авах эрхийнхээ тухай мэддэг бөгөөд уг эрхээ эдэлдэг төрийн байгууллагууд өөрсдийн санаачилга, эсвэл хүсэлт шаардлагын аль алины дагуу мэдээлэл гаргаж өгдөг
тусгай эрх бүхий мэдээллийн комиссар эсвэл омбудсмен гэх мэт хараат бус захиргааны этгээдээр дамжуулсан үр дүн, үр ашиг бүхий давж заалдах механизмтай
олон нийтийн хууль ёсны ашиг сонирхол бүхий мэдээллийг орхигдуулахгүйн тулд хувь хүний нууцыг хамгаалах үндэслэлээр аливаа хязгаарлалтыг нарийвчлан тодорхойлдог

Нотлох аргууд

- олон улсын стандартад нийцсэн мэдээлэлтэй байх эрхийн тухай аливаа хууль тогтоомж, бодлого
- мэдээлэлтэй байх эрхийн баталгаажуулалтын талаар итгэл даахуйц байгууллагын тайлан

- мэдээлэл өгөх талаар төрийн байгууллагын бодлого
- шүүхийн шийдвэр, парламентын хуралдааны тэмдэглэл, зарцуулалтын тайлан зэрэг бичиг баримтыг нийтлэх, түгээх зэргээр нээлттэй болгох засгийн газрын хүсэл зоригийн нотолгоо
- албан ёсны мэдээлэл авахаар олон нийтээс тавьсан хүсэлтийн тоо, тэдгээрийг биелүүлсэн эсвэл татгалзсан тухай
- мэдээлэл хүсэхэд татгалзсан тохиолдолд гомдол мэдүүлсэн, давж заалдсан статистик

1.3. РЕДАКЦИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛСАН, АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

өргөн нэвтрүүлэгчдийг засгийн газарт өргөн нэвтрүүлгийн цаг хуваарилах (сонгуулийн үеэр улс төрийн өргөн нэвтрүүлэгт цаг олгохоос бусад) эсвэл засгийн газрын өмнөөс тусгай нэвтрүүлэг явуулахыг шаарддаггүй засгийн газрын зохицуулалтын этгээд эсвэл арилжааны ашиг сонирхол өргөн нэвтрүүлэг, сонин хэвлэлийн редакцийн агуулгад нөлөөлөхгүй байх, эсвэл нөлөөлөхийг оролддог онц байдлын үеэр өргөн нэвтрүүлэгчдэд төрийн байгууллагууд хяналт тавихыг хуулиар зөвшөөрдөггүй

Нотлох аргууд

- редакцийн хараат бус байдлын тухай олон улсын стандартуудад нийцсэн аливаа хууль тогтоомж, бодлого
- редакцийн шийдвэр гаргахад төрийн эсвэл хувь этгээдүүд хөндлөнгөөс оролцдог тухай баримт нотолгоо
- редакцийн хараат бус байдлын асуудлаарх итгэл даахуйц байгууллагуудын тайлан

1.4. СЭТГҮҮЛЧИЙН ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ ЭРХИЙГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛЖ, АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

сэтгүүлчид айдасгүй, шүүхийн дарамтаас эмээхгүй эсвэл элдэв хавчлагагүй эх сурвалжийнхаа нууцыг хамгаалж чаддаг

Нотлох аргууд

- сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг албадсан тохиолдлуудын баримт нотолгоо
- олон улсын стандартуудад нийцсэн, эх сурвалжийн нууцыг хамгаалахтай холбоотой аливаа эрх зүйн баталгаа
- хэвлэл мэдээллийн байгууллагууд, эсвэл мэргэжлийн эвлэл холбоод нууц эх сурвалжийг хамгаалах эрхийг идэвхтэй хамгаалж буй тухай баримт нотолгоо

1.5 ОЛОН НИЙТИЙН БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО БОЛОВСРУУЛАХАД ОРОЛЦДОГ

төр засаг нь төрийн бүтцийн бус этгээдүүдэд хэвлэл мэдээллийн хууль тогтоомж, бодлого боловсруулахад бодитоор оролцох боломж олгодог

Нотлох аргууд

- хэвлэл мэдээлэлтэй холбоотой хууль, бодлого боловсруулахад иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах төр засгийн хүсэл эрмэлзэл (жишээлбэл, бага хурал, семинар, олон нийтийн зөвлөгөөн, агаарын долгион болон сонин хэвлэлийн мэтгэлцээнд албан ёсоор тататн оролцуулдаг зэрэг)-ийн баримт

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Хүний ба улс түмний эрхийн төлөөх Африкийн Комисс, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч: www.achpr.org/english/_info/index_free_exp_en.html

19-р зүйл, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation*, March 2002: www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf

Европын Консул, сэтгүүлчдийн мэдээллийн нууцаа илчлэхгүй байх эрхийн тухай Зөвлөмж 7 (2000): www.humanrights.coe.int/media/index.htm

Freedominfo.org – мэдээллийн эрх чөлөө хамгаалагчдын онлайн сүлжээ: *Дэлхий даяарх мэдээллийн эрх чөлөө 2006: төр засгийн баримт бичгийн хүртээмжийн тухай хуулийн судалгаа*: www.freedominfo.org/documents/global_survey2006.pdf

Олон улсын сэтгүүлчдийн холбооны эх сурвалж хамгаалах кампанит ажил: www.ifj-europe.org/default.asp?Issue=EFJsources&Language=EN

Олон улсын сэтгүүлчдийн сүлжээ – улс орнуудын хэвлэлийн хуулийн судалгаа: www.ijnet.org/Director.aspx?P=MediaLaws

Олон улсын сэтгүүлчдийн сүлжээ – хэвлэл мэдээлэлтэй холбоотой үндсэн хуулийн зүйл заалтын тухай олон улсын лавлах: www.ijnet.org/Director.aspx?P=MediaLaws&cat=2

Хэвлэл мэдээллийн тогтвортой байдлын индекс: www.irex.org/msi

Америкийн муж улсуудын байгууллага (OAS)-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тусгай илтгэгч: www.cidh.org/Relatoria/index.asp?IID=1

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч: www.osce.org/fom

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (UNDP), *Мэдээллийн эрх чөлөө – практик хөтөчийн тэмдэглэл*, 2004, Andrew Puddephatt:

www.undp.org/oslocentre/docs04/Right%20to%20Information.pdf

ЮНЕСКО, *Мэдээллийн эрх чөлөө: Тоби Менделийн харьцуулсан судалгаа*, 2003: www.article19.org/docimages/1707.pdf

НҮБ-ын үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч: www.ohchr.org/english/issues/opinion/index.htm

World Press Freedom Committee: www.wpfc.org

НҮБ, бүсийн бусад холбогдох байгууллагууд зэрэг олон улсын байгууллагуудын цахим хуудсуудад гэрээгээр хүлээсэн үүргүүдийн талаар хамгийн сайн эх сурвалжтай. Эдгээр нь гэрээ тус бүр, түүнчлэн гарын үсэг зурсан, соёрхон баталсан улс орнууд, гэрээний байгууллагын хэрэгжилтийн талаарх ерөнхий санал зөвлөмжийн тухай мэдээлэл агуулсан.

Түүнчлэн, олон улс, бүсийн тусгай илтгэгчдийн улс орнуудад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх тайлан

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрхтэй холбоотой олон улсын эрх зүйн гол баримт бичгүүд нь:

Хүний ба улс түмний эрхийн төлөөх Африкийн тунхаглалын 9-р зүйл:

www.achpr.org/english/_info/charter_en.html

Америкийн хүний эрхийн конвенцийн 13-р зүйл: www.oas.org/juridico/english/Treaties/b-32.htm

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц:

<http://conventions.coe.int/treaty/Commun/QueVoulezVous.asp?CL=ENG&NT=005>

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйл:

www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйл: www.un.org/Overview/rights.html

Дотоодын хууль тогтоомж, Үндсэн хуулийн баталгаажуулалтын тухай мэдээлэл нь дотоодын архив, эрх зүйн комисс, парламентын болон засгийн газрын албан ёсны баримт бичгүүдээс үзэж болно.

V. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны зохицуулалтын салбар, тэр дундаа тусгай зөвшөөрөл олгох, олон нийтийн санал гомдлыг хүлээн авах эрх бүхий төрийн байгууллагуудад хамааралтай удирдлагын хэд хэдэн зарчим байдаг. Эдгээр зарчмууд нь ЮНЕСКО-гийн Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг хөхиүлэн дэмжих, Байгууллагын Ерөнхий бага хурлаар батлагдсан 5 Тунхаглалд тусгагдахын зэрэгцээ засгийн газар хоорондын бусад байгууллага, мэргэжлийн хараат бус эвлэл холбоодын хүлээн зөвшөөрсөн бичвэрүүдэд буй. (жишээ нь, 19-р зүйл байгууллагын Эфирийн хүртээмж Article 19, Access to Airwaves.)

Зохицуулалтын тогтолцоо нь олон нийтэд үйлчлэхийн тулд оршдог. Зохицуулагч байгууллагууд улс төр, арилжааны нөлөөнөөс ангид бие даасан, хараат бус байх ёстой бөгөөд гишүүд нь ил тод, ардчилсан зарчмаар сонгогдох ёстой. Эдгээр байгууллагын эрх

мэдэл, үүрэг хариуцлага, үүний дотор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон талт байдал, шударга байдал, мэдээллийн чөлөөт урсгалыг дэмжих эрх зүйн тодорхой шаардлага зэргийг хуулиар тогтоох шаардлагатай. Зохицуулагч байгууллага үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй байх ёстой. Мөн олон нийтийн өмнө хариуцлага хүлээх шаардлагатай. Үүнийг ихэвчлэн хууль тогтоох байгууллагаар дамжуулан гүйцэтгэдэг.

Зохицуулагч нь олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тохирох шийтгэл ногдуулах зэргээр эрх мэдлээ хэрэгжүүлж, үүрэг хариуцлага хүлээдэг баримт нотолгоо байх шаардлагатай.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.6. ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛЖ, АМЬДРАЛ ДЭЭР ХЭРЭГЖҮҮЛДЭГ

нэг талыг барьсан буюу арилжааны оролцооноос бие даасан, хараат бус байх эрх зүйн баталгаа

зохицуулагч байгууллагын хараат бус байдлын эрх зүйн баталгаа

зохицуулагч байгууллагын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хуулинд тодорхой тусгагдсан

зохицуулагч байгууллагын ил тод, ардчилсан зарчмаар сонгогдсон гишүүд нь нэг талыг барьсан буюу арилжааны нөлөөний эрсдэл бууруулах зорилгод нийцсэн (жишээ нь, үл нийцэх, нийцэх байдалд дүрэм журам гаргах)

зохицуулагч байгууллагын хараат бус байдлыг сахин хамгаалах эсвэл төсвийн дарамтаас ангид байлгахын тулд хангалттай, тогтмол санхүүжилтийг хуулиар батлгаажуулсан

Нотлох аргууд

- зохицуулагч байгууллагын үүрэг, гишүүнчлэл, санхүүжилттэй холбоотой аливаа хууль тогтоомж
- зохицуулагч байгууллагын хараат бус байдлын тухай үндсэн хуулийн аливаа зүйл заалт
- зохицуулагч байгууллагын үр дүнтэй бие даасан, хараат бус байдлын талаар гаргасан тайлан

1.7 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОЛОН УРГАЛЬЧ БАЙДАЛ, ЧӨЛӨӨТ ИЛЭРХИЙЛЛИЙН БОЛОН МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХЫН ТУЛД ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО ҮЙЛЧИЛДЭГ

зохицуулагч байгууллага нь олон нийтийн өмнө албан ёсоор үүрэг хариуцлага

хүлээдэг

зохицуулагч байгууллага нь өргөн нэвтрүүлгийн салбарт шударга, олон ургальч, үр дүнтэй үйл ажиллагааг хангах зорилготой бөгөөд шударга ёс, үзэл бодлоо илэрхийлэх, санаа бодол, өмчлөлийн эрх чөлөөг дэмжих, олон нийтийн үйлчилгээний хөтөлбөр, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг олон нийтэд хүргэх зэрэг эрх мэдэлтэй

Нотлох аргууд

- хэвлэл мэдээллийн олон ургальч байдал, чөлөөт илэрхийллийн болон мэдээлэлтэй байх эрх чөлөөг хөхиүлэн дэмжихийг зохицуулагч байгууллагаас шаардсан аливаа хууль тогтоомж
- зохицуулагч байгууллагын дээрх зорилтод хүрсэн тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- чөлөөт, олон ургальч хэвлэл мэдээллийг хангах талаарх зохицуулагч байгууллагын үйл ажиллагаа

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Африкийн Харилцаа холбооны зохицуулах байгууллагын сүлжээ (African Communication Regulation Authorities' Network): www.acran.org/index.en.php

19-р зүйл, Эфирийн хүртээмж: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын зарчмууд (Article 19, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation*), March 2002:

www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf

19-р зүйл, Өргөн нэвтрүүлгийн олон ургальч, олон талт байдал. Африкийн зохицуулагчдад зориулсан сургалтын гарын авлага (Article 19, *Broadcasting Pluralism and Diversity: Training Manual for African Regulators*), 2006: www.article19.org/pdfs/tools/broadcasting-manual.pdf

European Platform of Regulatory Authorities (EPRA):

www.epra.org/content/english/index2.html

EPRA – directory of broadcasting regulation entities worldwide:

www.epra.org/content/english/authorities/regulation.html

UNESCO and Commonwealth Broadcasting Association: *Guidelines for Broadcasting Regulation* by Eve Salomon, 2006: http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=21345&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

С. ГҮТГЭЛЭГ, НЭР ТӨРТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ БА СЭТГҮҮЛЧДЭД ТАВЬЖ БҮЙ ЭРХ ЗҮЙН БУСАД ХЯЗГААРЛАЛТ

АГУУЛГА БА ГОЛ АСУУДЛУУД

Нэр төр гутаахтай холбоотой хууль болон бусад хязгаарлалтууд улс бүрт өөр өөр байдаг. Зарим оронд нэр төр гутаахтай холбоотой тусгай хууль тогтоомж байдаг боловч ихэвчлэн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалт нь иргэний эсвэл эрүүгийн зэрэг ерөнхий хуулиудад тусгагдсан байдаг. Иргэний шүүх нь шударга бус, худал эсвэл хор хохирол учруулахуйц хэвлэлийн мэдээ, сурвалжлага, ялангуяа жирийн иргэдийн нэр төрд хор хохирол учруулахтай холбоотой хэрэг шийдвэрлэх тохиромжтой газар юм.

Нэр төр гутаахтай холбоотой хууль тогтоомж нь хувь хүний нэр төрд халдсан худал мэдүүлгээс хамгаалах зорилготой байдаг. Гэсэн хэдий ч, 19-р зүйл байгууллагын “Түтгэлгийн цагаан толгой” гарын авлагад ихэнх улс оронд нэр төр гутаахтай холбоотой хууль нь “үзэл бодол илэрхийлэх эрх чөлөөнд хэт өргөн хязгаарлалт болдог” хэмээн тэмдэглэсэн байна. 19-р зүйл байгууллагын үзэж буйгаар, нэр төр гутаахтай холбоотой хууль нь тайлбарын хувьд хэт өргөн хүрээний байх магадлал бүхий хангалттай эрх зүйн хамгаалалт үзүүлж чадахгүй, өмгөөлөл үзүүлэхэд хэт өндөр өртөгтэй, эсвэл зөрчсөн тохиолдолд эрүүгийн шийтгэл эсвэл хэт өндөр торгууль зэрэг хүнд шийтгэл ногдуулдаг.

Чадвар муутай буюу алдаатай боловсруулсан хууль тогтоомж нь иргэдийн санаа бодлоо илэрхийлэхээс зайлсхийхэд хүргэх боломжтой ба хэвлэл мэдээллийн өөрийн цензур бий болгоход хүргэж болно. НҮБ-ын Тусгай илтгэгчдийн үзэж буйгаар иргэний хуулиар ч хувь хүний нэр төрийг хамгаалах боломжтой тул нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хууль нь үндэслэлгүй. Нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийг олон нийтийн мэтгэлцээн, төрийн байгууллага эсвэл төр засгийн удирдлагуудыг шүүмжлэхээс сэригйлэхийн тулд ашигладаг.

Зарим оронд эрх баригчдын нэр төрд халдах, эсвэл төрийн далбаа, үндэсний бусад бэлгэ тэмдэг зэргийг гутаан доромжлоход ногдуулах шийтгэл нь бусад хэргээс хүнд байж болох, эсвэл эрх мэдэлтнүүд нь олон нийтийн анхаарлыг өөртөө татахгүйн тулд хэт урт хугацааны шүүхийн зарга үүсгэдэг.

Хэвлэл мэдээлэлд ногдуулах эрх зүйн бусад үндэслэлгүй хязгаарлалт ирээдүйн сэтгүүлчдэд магадлан итгэмжлэл авахад төвөгтэй, бүртгэл эсвэл тусгай зөвшөөрлийн бүдүүвчид саад тотгор болж болно. Түүнчлэн, эрх баригчдад нийгмийн дэг журам, нийгмийн ёс зүй, албаны нууц, гүтгэлэг доромжлол, эмх замбараагүй байдалд уриалан дуудах өөрчлөлтөд өртөмхий, субъектив тодорхойлолт бүхий асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хязгаарлалт тавих эрх олгох хууль тогтоомж үйлчилж болно. Дээрх асуудал зарим тохиолдолд ээдрээтэй нөхцөл бүрдүүлж, албан тушаалаа урвуулан ашиглах боломж нэмэгдүүлснээр нэр төр гутаахтай холбоотой хуулийн заалтад тусгагдаж болно. Сүүлийн жилүүдэд үндэсний аюулгүй байдал нэн тэргүүнд санаа зовоох асуудал болж, үзэл бодол илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд хэт хязгаарлалт тавьж байна.

Шашин шүтлэг хамгаалахтай холбоотой хязгаарлалт нэмэгдэж байна.

Үндсэндээ, хэвлэл мэдээлэлд ногдуулах эрх зүйн ямар ч хязгаарлалт нь ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай хэмээн шүүхийн байгууллага хүлээн зөвшөөрөх ёстой. Эдгээр хязгаарлалтууд нь олон нийтийн эрх ашигт нийцэх, эдгээр эрх ашгийг хамгаалахын тулд аль болох нарийвчлан тодорхойлогдсон, үзэл бодол илэрхийлэх эрх чөлөөнд аль болох бага хор хохирол учруулж, өөрийн хүрээ, ногдуулах шийтгэлд аль болох эрх тэгш хандах ёстой. Удирдлагын эдгээр зарчмууд нь үзэн ядалтаас үүдсэн үг хэллэгийг хориглох эсвэл хувь хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль тогтоомж зэрэг хэвлэл мэдээлэлд шударга, хууль ёсны хязгаарлалт хийхэд нөлөөлнө.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.8 ТӨР ЗАСГААС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛГҮЙ ХЯЗГААРЛАЛТ ХИЙДЭГГҮЙ

сэтгүүл зүйн үйл ажиллагааг хэн эрхэлж болохыг заасан эсвэл сэтгүүлчдийг тусгай зөвшөөрөл, бүртгэлтэй байхыг шаардсан хуулийн заалт байдаггүй төрийн байгууллагын үйл ажиллагааг сурвалжлахад шударга, ил тод магадлан итгэмжлэл олгодог

Нотлох аргууд

- сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардах бүртгэл, тусгай зөвшөөрлийн тогтолцоо эсвэл бусад саад тотгор байдаг
- магадлан итгэмжлэлийн журам ба түүний ил тод байдал
- гүтгэх, доромжлох хэргийг эрүүгийн хуулиар бус иргэний журмаар шийддэг эрх зүйн тогтолцоотой

1.9 НЭР ТӨР ГУТААХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖООР ХУВЬ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ХАМГААЛАХЫН ТУЛД ХАМГИЙН БАГА ХЯЗГААРЛАЛТ ХИЙДЭГ

нэр төр гутаахтай холбоотой хуулиар албан тушаалтнууд, төрийн байгууллагын төлөв байдлын талаар олон нийтийн дунд мэтгэлцээн явуулахыг хориглодоггүй шалгагдаж буй хэрэг нь баримт нотолгоо бус санал бодол байсан бол, нийтлэл эсвэл нэвтрүүлэг нь үндэслэлтэй эсвэл олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, эсвэл уг мэдэгдлийг шууд нэвтрүүлгээр дамжуулсан эсвэл шүүхийн буюу сонгогдсон байгууллагын өмнө явагдсан тохиолдолд нэр төр гутаахтай холбоотой хууль нь эрх зүйн хангалттай хамгаалалт үзүүлдэг
нэр төр гутаахтай холбоотой хууль нь гүтгэлэг, доромжлол агуулсан нийтлэл буюу дамжуулсан мэдээ, мэдээлэлд ижил хариуцлага хүлээлгэх заалттай

нэр төр гутаахтай холбоотой хуулийн хүрээ, түүнчлэн гомдол гаргах этгээд хэн байж болох талаар аль болох нарийн тодорхойлсон
нэр төр гутаагдсан гэх гомдлыг хуулийн гүйцэтгэх, шүүх зэрэг төрийн байгууллагууд гаргах боломжгүй
төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой болон олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн хэргээр гомдол гаргагч этгээд нь гүтгэгдсэн гэх баримт нотолгоог өөрөө гаргаж өгдөг
нэр төр нь гутаагдсан гэх гомдлыг үндэслэл бүхий хугацаа өнгөрсөн тохиолдолд гаргах эрхгүй байдаг

1.10 ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БУСАД

ХЯЗГААРЛАЛТУУДЫГ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЗЭН ЯДАЛТААС ҮҮДСЭН ҮГ ХЭЛЛЭГ, ХУВЬ ХҮНИЙ НУУЦ, ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ҮЛ БИЕЛҮҮЛЭХ БОЛОН ЗҮЙ БУСААР АВИРЛАХ ЯВДАЛ ЗЭРЭГТ ҮНДЭСЛЭН ХУУЛИНД ТОДОРХОЙ БӨГӨӨД НАРИЙН ЗААЖ, АРДЧИЛСАН НИЙГЭМД ЗАЙЛШГҮЙ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨЖ, ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН

үндэсний аюулгүй байдал, бусад хязгаарлах хууль тогтоомж нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн асуудлаар тэднийг мэтгэлцээн явуулахыг хориглодоггүй аливаа хязгаарлалтыг гүйцэтгэх засаглалын үзэмжээр бус хуулиар нарийн тодорхойлж, шийддэг
эдгээр хууль тогтоомж олон нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг

Нотлох аргууд

- олон улсын тэргүүн туршлагын стандартад нийцсэн нэр төр гутаахтай холбоотой аливаа хууль тогтоомж
- нэр төр гутаахтай холбоотой хуулийг мэргэжлийн сэтгүүл зүйн хүрээ, мэргэжилтнүүд, иргэний нийгмийн дунд хэлэлцүүлэг явуулсан тохиолдлууд
- хэвлэл мэдээллээр төрийн албан хаагчид, төрийн байгууллагыг ял шийтгэлгүйгээр шүүмжилж болох хязгаар
- нэр төр гутаахтай холбоотой заргууд
- үндэсний аюулгүй байдал, үзэн ядалтаас үүдсэн үг хэллэг зэрэг шалтгаанаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан аливаа хууль тогтоомж
- хязгаарлалтын хуулийн тууштай хяналтыг илтгэх шүүхээр шийдэгдсэн хэргүүд

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19 – *Defamation ABC: a Simple Guide to Key Concepts of Defamation Law*:

www.article19.org/pdfs/tools/defamation-abc.pdf

Article 19 – other resources relating to defamation, including country reports:

www.article19.org/publications/global-issues/defamation.html

Council of Europe Defamation Guide: [http://i-](http://i-policy.typepad.com/informationpolicy/2006/03_council_of_euro.html)

[policy.typepad.com/informationpolicy/2006/03_council_of_euro.html](http://i-policy.typepad.com/informationpolicy/2006/03_council_of_euro.html)

Inter-American Press Association – press laws database:

www.sipiapa.org/projects/chapul-presslaws.cfm

International Federation of Journalists – resources and links relating to defamation: www.ifj-asia.org/page/resources.html

International Freedom of Expression eXchange: Campaign on Insult and Criminal Defamation Laws: <http://campaigns.ifex.org/def/index.html>

International Journalists’ Network – survey of media laws worldwide: www.ijn.net/Director.aspx?P=MediaLaws

Media Institute of Southern Africa and UNESCO, 2004: *Undue Restriction: Laws impacting on media freedom in the SADC*: www.misa.org/documents/undue.pdf

D.ЦЕНЗУР

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Олон улсын хууль хэм хэмжээгээр урьдчилсан цензурыг үндэсний эрх ашигт аюул заналхийлэл учрах гэх мэт онцгой тохиолдолд зөвшөөрдөг. Олон нийтийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахын тулд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний аливаа хязгаарлалтыг хийх бөгөөд уг эрх ашгийг хамгаалахын тулд нарийвчлан тодорхойлсон байх ёстой.

Үзэл бодлын чөлөөт илэрхийллийн тухай Олон улсын гэрээнд гарын үсэг зурж, соёрхон баталсан зарим улс орнууд өөрийн хууль тогтоомж эсвэл үндсэн хуулиа зөрчиж урьдчилсан цензур тавьсаар байна.

Мэдээ түргэн хуучирдаг тул мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэх, нэвтрүүлэхийг хойшлуулах нь чөлөөтэй илэрхийлэх эрхийг ноцтой зөрчдөг.

Нийтийн дэг журам, олон нийтийн ёс зүй эсвэл аюулгүй байдалд хор учруулах, эсвэл бусад улс орнуудтай харилцах харилцаанд муу нөлөөлөхүйц нийтлэлийг хориглох зэрэг хэт өргөн хүрээтэй эсвэл муу боловсруулсан хуулиуд бол чөлөөт үгэнд хор хохиролтой нөлөө үзүүлнэ. Хэт хүнд шийтгэл болох өндөр торгууль ногдуулах эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох, зогсоохоор сүдүүлэх нь өөрийн цензурын

уур амьсгал бүрдүүлдэг. Эсрэгээрээ, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр нөлөөтэй тогтолцоо нь төр засгийн оролцоог шаардлагагүй болгодог (3.С Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт бүлгийг харна уу)

Интернет бол төр засгийн зүгээс мэдээллийн чөлөөт урсгалыг нь цагдан хянахыг оролддог мэдээлэл дамжуулах харьцангуй шинэ хэрэгсэл. Тиймээс ТББ-ууд болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөний чиглэлээр ажилладаг байгууллагууд түүнийг олон нийтийн эрх ашгийг үүднээс хамгаалахыг чармайдаг.

Удирдлагын зарчмуудад арилжааны үйлчилгээ үзүүлэгч эсвэл төр засгийн бус харин эцсийн хэрэглэгчээр хянуулдаг шүүлтүүрийн системийн хэрэгцээ шаардлагыг агуулдаг.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.11 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ХУУЛИАР БОЛОН ПРАКТИК ДЭЭР УРЬДЧИЛСАН ЦЕНЗУР БУЮУ ЦАГДАН ХЯНАЛТАД АВТААГҮЙ

өргөн нэвтрүүлгийн буюу хэвлэлийн агуулгыг төр засаг, зохицуулагч байгууллагын аль алины зүгээс цагдан хянадаггүй агуулгатай холбоотой зохицуулалтын журмыг зөрчсөн тохиолдолд тухайн мэдээ, нийтлэл цацагдсан буюу нийтлэгдсэний дараа шийтгэл ногдуулдаг өргөн нэвтрүүлэгч, хэвлэн нийтлэгчийг төрийн байгууллагад бүртгүүлэх эсвэл түүнээс зөвшөөрөл авах шаарддаггүй өргөн нэвтрүүлэгч, хэвлэн нийтлэгчийн үйл ажиллагааг агуулгын улмаас зогсоох, эсвэл зогсоохыг шаарддаггүй хэвлэлийн нийтлэл, түгээлтийн сүлжээ эсвэл хэвлэх үйлдвэрийн хүртээмжид ил эсвэл далд хязгаарлалт байхгүй журам зөрчсөн тохиолдолд цензурын нэг хэлбэр болох хэт өндөр буюу тэгш бус торгууль ногдуулдаггүй

Нотлох аргууд

- хэвлэл мэдээллийн цензурыг зөвшөөрсөн эсвэл шаардсан аливаа зохицуулалт буюу албан ёсны механизм
- хэвлэл мэдээллийн цензурын тухай итгэл даахуйц байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тайлан
- сонин хэвлэл эсвэл өргөн нэвтрүүлэгчдийн үйл ажиллагааг хүчээр зогсоосон, хориглосон тоо, баримт

1.12 ТӨРИЙН ЗҮГЭЭС ХОР УРШИГТАЙ БУЮУ АЮУЛТАЙД ТООЦОГДОХ ИНТЕРНЕТИЙН АГУУЛГЫГ ХААХ, ШҮҮЛТҮҮР ХЭРЭГЛЭХ ОРОЛДЛОГО ХИЙДЭГГҮЙ

төрийн зүгээс агуулга эсвэл эх сурвалжийн улмаас интернетийг хаах эсвэл түүнд шүүлтүүр хэрэглэдэггүй

хор уршигтай буюу аюултайд тооцогдох интернетийн агуулга хүртэх эсвэл нийтэлсний улмаас интернет хэрэглэгчдийг шийтгэдэггүй

интернетийн үйлчилгээ үзүүлэгч, цахим хуудас, блог эсвэл интернетийн өргөн нэвтрүүлэгчдийг төрийн байгууллагын зүгээс бүртгүүлэх эсвэл зөвшөөрөл авахыг шаарддаггүй

Нотлох аргууд

- аюултай үр дагавар буюу хор уршиг бүхий агуулга хүртсэн буюу нийтэлсэн интернетийн хэрэглэгчдийг шийтгэсэн тохиолдол
- цахим хуудсын үйл ажиллагааг хүчээр зогсоосон эсвэл зогсоохыг сүрдүүлсэн тохиолдол
- интернетийн хэрэглэгчид зохимжгүй хэмээн тооцогдох мэдээ эсвэл санаа бодол хүртсэн эсвэл нийтэлсний улмаас шийтгэл эдэлсэн
- төрийн зүгээс цахим хуудсыг хаасан эсвэл түүнд шүүлтүүр хэрэглэсэн тохиолдол

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Amnesty International – campaign on censorship: [http://irrepressible.info/Article 19](http://irrepressible.info/Article%2019) – resources and links relating to censorship: [www.article19.org/publications/global-issues/ censorship.html](http://www.article19.org/publications/global-issues/censorship.html)

Committee to Protect Journalists: www.cpj.org

Freedom House: www.freedomhouse.org

Freedom of Expression Institute (South Africa) – anti-censorship programme:

www.fx.org.za/Main%20Pages/anti_censorship.html

Gus Hosein, *Politics in the information society: the bordering and restraining of global data flows*, UNESCO 2005: [http://portal.unesco.org/ci/en/ev.php-](http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=17659&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

[URL_ID=17659&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html](http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=17659&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

Human Rights Watch – country reports including information on censorship of the media: <http://hrw.org/>

Index on Censorship: www.indexonline.org International Freedom of Expression exchange: information and activities on Internet censorship: www.ifex.org/en/content/view/full/235/

Internet Free Expression Alliance – links and resources relating to Internet censorship: www.ifea.net

Internet Governance Forum – supports UN Secretary-General to carry out mandate of World Summit on the Information Society: www.intgovforum.org

Internet Governance Project – international consortium of academics and practitioners on Internet governance and policy: www.internetgovernance.org

Journalism Net – news on censorship: www.journalismnet.com/media/censorship.htm

Libertus.net – international links relating to Internet censorship laws:

<http://libertus.net/censor/resources.html#Global> Re porters sans Frontiieres: www.rsf.org

Ангилал 2. Хэвлэл мэдээлэл олон ургальч, олон талт байдал, эдийн засгийн түвшин, өмчлөлийн ил тод байдал

А. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТӨВЛӨРӨЛ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хэвлэл мэдээллийн өмчлөлийн төвлөрлөөс сэргийлэх олон арга байдаг. Төр засгаас хувь хүн, гэр бүл, компани эсвэл бүлэг хүмүүс нэг болон түүнээс дээш хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нөлөөлөхийг хязгаарласан журам батлахын зэрэгцээ хангалттай тооны хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон талт холимог байдлыг баталгаажуулж болно.

Эдгээр журам үзэгч, сонсогчдын хувь хэмжээ, дамжуулалт, эргэлт/ашиг орлого, түгээлт эсвэл хувь нийлүүлсэн хөрөнгө эсвэл сонгуульд оролцох эрх зэрэг бодит хэмжүүрт үндэслэсэн хязгаарлалтын зааг агуулж болно.

Түүнчлэн эдгээр журмуудад хэвтээ (үйл ажиллагааны нэг салбар дахь нэгдэл) босоо (бүтээмж, түгээлтийн үйл явцын үндсэн элемент, зар сурталчилгаа зэрэг холбогдох үйл ажиллагааг хувь хүн, компани эсвэл бүлэг хүмүүс хянах) интеграцийн аль алиныг нь харгалзана.

Зохицуулалтын хэлбэр нь үндэсний, бүсийн эсвэл орон нутгийн хэвлэл мэдээллийн зах зээлийн хөгжлийн цар хүрээ, түвшингээс хамаарна.

Холбогдох хууль тогтоомж байхгүй тохиолдолд, хуулийн төсөл боловсруулагдаж байгаа эсэх, түүнийг хэрэгжүүлэх бодит байдал дээр үндэслэсэн цагийн хуваарь буй эсэх, мөн хуулийн төсөл нь олон улсын стандартад нийцэж буй эсэхийг судлах нь зүйтэй.

Үүнээс гадна, хууль хүчтэй байх шаардлагатай. Хуулийн хэрэгжилтийг хариуцах эрх баригчид нь үүргээ гүйцэтгэхэд хангалттай эрх мэдэлтэй байх, хараат бус байж, улс

төрийн аливаа дарамтаас ангид үйл ажиллагаа явуулах ёстой. Тэд мөн, олон ургальч байдалд заналхийлсэн эсвэл хэт төвлөрөл үүссэн тохиолдолд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанаас татгалзах, шаардлагатай үед хариуцлага хүлээлгэх эрх мэдэлтэй байх ёстой. Мөн эдгээр эрх мэдлээ зохистой хэрэгжүүлэхэд хяналт тавих механизмыг харгалзан үзэх нь зүйтэй.

Олон улсын болон бүсийн тэргүүн туршлагын стандартууд дотоодын арга хэмжээг үнэлэх хэмжүүр бий болгодог. Хэвлэл мэдээллийн олон ургальч байдал, хэвлэлийн агуулгын олон талт холимог байдлын талаар Европын зөвлөлийн 2007 оны санал зөвлөмжүүдээс үзэж болно.

Төвлөрлийн эсрэг хууль тогтоомж, зохицуулалт буй эсэх, тэдгээрийн хэрэгжилтийг баримтжуулах нь зүйтэй. Редакцийн шийдвэр, өмчлөгч хоорондын холбоог илрүүлэх агуулгын дүн шинжилгээнд тоон ба чанарын үзүүлэлтийн аль аль нь байх ёстой. Жишээлбэл, тодорхой улс төрийн намд эфирийн хэдэн хуваарилсныг хэмжих боломжтой байхад хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшигчээс нь хамаарч ялгаварлахад чанарын үнэлгээ хийж болно.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 ТӨР ЗАСГААС ОЛОН УРГАЛЬЧ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ДЭМЖИХЭД НААШТАЙ АРГА ХЭМЖЭЭ АВДАГ

өмчлөлийн хэт төвлөрлөөс сэргийлэх үр дүнтэй зохицуулалт болон олон ургальч байдлыг хөхиүлэн дэмждэг
зах зээлийн давамгайл байдлаас сэргийлэхийн тулд өргөн нэвтрүүлгийн бүтэц дотор эсвэл өргөн нэвтрүүлэгчдийн хооронд болон бусад хэвлэл мэдээллийн салбар дахь холимог өмчлөлийн тухай тусгай хууль тогтоомжтой
хэвлэл мэдээллийн зах зээл дэх том, жижиг оролцогчдын хоорондын ялгааг хүлээн зөвшөөрсөн зохицуулалттай
хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл, хөрөнгө оруулалт, орлогын эх үүсвэрийг нээлттэй, ил тод байлгахыг шаардсан зүйл заалттай
тусгай зөвшөөрлийн үйл явц хэвлэл мэдээллийн өмчлөл, хөтөлбөрийн агуулгын олон талт байдлыг хөхиүлэн дэмжих
олон улсын стандартад нийцдэг
монополийн эсрэг хууль хэрэгжүүлэх үүрэгтэй эрх баригчид хангалттай эрх мэдэлтэй, тухайлбал тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах, олон ургальч байдалд заналхийлсэн эсвэл нэг хүний гарт өмчлөлийн хэт төвлөрөл үүссэн зэрэг тохиолдолд хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зогсоох эрх мэдэлтэй байдаг

төр засаг, хэвлэл мэдээллийн төвлөрлийн асуудалд идэвхтэй дүн шинжилгээ хийж, үр дагаварт үнэлгээ хийдэг

2.2 ТӨР ЗАСАГ ОЛОН УРГАЛЬЧ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДҮҮЛДЭГ

хэвлэл мэдээллийн өмчлөлийн хэт төвлөрлөөс зайлсхийхийн тулд зохицуулагч байгууллага монополийн эсрэг хуулийн дагуу тусгай зөвшөөрлөөс татгалзах эсвэл хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг албан хүчээр зогсоодог иргэний нийгмийн бүлгүүд, иргэд хэвлэл мэдээллийн олон ургальч хөгжлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг дэмжиж, сахин биелүүлэхэд идэвхтэй оролцдог зохицуулагч байгууллагууд арилжааны болон арилжааны бус олон талт байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгодог

Нотлох аргууд

- харилцааны зохицуулагч дотоодын байгууллагын албан ёсны мэдэгдэл, цахим хуудаст хэвлэл мэдээллийн өмчлөлийн зохицуулалтын асуудал, тэдгээрийн үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг тусгасан
- өмчлөлийн хэт төвлөрлөөс сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх итгэл даахуйц байгууллагын (дотоодын, олон улсын байгууллага, төрийн бус, иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрчний эвлэл зэрэг) тайлан
- хэвлэл мэдээллийн редакцийн агуулга, өмчлөлийн хоорондын уялдаа холбоонд агуулгын дүн шинжилгээ хийдэг итгэл даахуйц байгууллагын тайлан (жишээ нь ОУСХолбооны Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чанарын талаар хэрэгжүүлсэн төсөл)
- дотоодын хэвлэл мэдээллийн хүрээнд хэвлэл мэдээллийн төвлөрлийн асуудлыг тусгадаг
- тоон тусгай зөвшөөрөл олголтыг зохицуулах аливаа хууль тогтоомж, түүний хэрэгжилт
- дотоодын мэдээлэл, харилцааны зохицуулагч байгууллагын албан ёсны мэдэгдэл, цахим хуудаст тоон өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын асуудлыг тусгасан
- хэвлэл мэдээллийн төвлөрлийн талаар иргэний нийгмийн байгууллагын гаргасан тайлан, төр засгаас өмчлөлийн олон талт байдлыг дэмжсэн арга хэмжээ
- төр засаг, иргэний нийгэмтэй зөвлөлдөх замаар хамтран ажилладаг

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19 – country-specific analyses of legislation governing media concentration:

www.article19.org

Columbia Journalism Review – *Who Owns What*: online guide to what major media companies own: www.cjr.org/tools/owners

Council of Europe; *Recommendation CM/Rec (2007) 2 of the Committee of Ministers to member states on media pluralism and diversity of media content* (adopted 31 Jan 2007):

<https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1089699&>

[BackColorInternet=9999CC&BackColorIntranet=FFBB55&BackColorLogged=FFAC75](https://wcd.coe.int/ViewDoc.jsp?id=1089699&BackColorInternet=9999CC&BackColorIntranet=FFBB55&BackColorLogged=FFAC75)

European Platform of Regulatory Authorities (EPRA): www.epra.org/content/english/index2.html

EPRA – international directory with web links to national regulatory authorities:

www.epra.org/content/english/authorities/regulation.html

International Federation of Journalists – Media Quality Project on Increasing Concentration of Media Ownership: www.ifj.org/default.asp?Index=3901&Language=EN

International Federation of Journalists, *Media Power in Europe: The Big Picture of Ownership* (2006): www.ifj.org/default.asp?Index=3671&Language=EN

International Federation of Journalists, *Who's in Control: a primer for the roundtable discussion on global media – threats to free expression*; contains directory of organisations and networks campaigning on the issue of media concentration:

www.ifj.org/pdfs/whosincontrol.pdf

International Freedom of Expression exchange – information on media concentration:

www.ifex.org/en/content/view/full/238/

Media & Society Foundation, International Standard, Quality Management Systems – Requirements for the press, ISAS P 9001:2005: www.media-society.org/download/ISAS%20P%209001%20Standard%20English-French.pdf

Media & Society Foundation, International Standard, Quality Management Systems – Requirements for Radio, TV Broadcasters and Internet Content

Producers, ISAS BC 9001:2003: [www.media-society.org/download/ -](http://www.media-society.org/download/-ISAS%20BC%209001%20Standard%20English.pdf)

[ISAS%20BC%209001%20Standard%20English.pdf](http://www.media-society.org/download/-ISAS%20BC%209001%20Standard%20English.pdf)

Media Institute of Southern Africa – Broadcasting Diversity and ICTs:

www.misa.org/broadcasting.html

Media Sustainability Index www.irex.org/msi

Media Watch Global: www.mwglobal.org

Open Society Institute – Media program: www.soros.org/initiatives/media

Open Society Institute, *Television across Europe: regulation, policy and independence* (2005); www.eumap.org/topics/media/television_europe

**В. ОЛОН НИЙТИЙН, ХУВИЙН, ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОЛОН ТАЛТ
ХОЛИМОГ БҮТЭЦ**

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Төрийн зүгээс олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэг, сонин хэвлэлийн олон талт холимог бүтцийг хангахын тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь улс бүрт өөр байдаг. Хүйн хэвлэл мэдээлэл гэдэг нь хүй олны эзэмшиж, ажиллуулдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм.

Зарим оронд хүйн өргөн нэвтрүүлэгт дагаж мөрдөх тодорхой стандарт, түүний үйлчилгээ үзүүлж байгаа нутаг дэвсгэрт хуулиар хүлээн зөвшөөрөх ямар нэг заалт байхгүй. Ийм тохиолдолд ашгийн бус хүйн өргөн нэвтрүүлэгчид нь хуулийн хүрээнд, зах зээлийн хүчин чадлаас хамааралтай хувийн станцын зарчмаар ажилладаг байна. Зарим улс орны хуулинд дээрх үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрдөггүй тул төр засгийн зүгээс хууль эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас зөвшөөрөл аваагүй хүйн өргөн нэвтрүүлэгчдэд хариуцлага хүлээлгэдэг.

Бусад тохиолдолд, өргөн нэвтрүүлгийг зохицуулах ерөнхий хууль байхгүй эсвэл тэр нь хуучирсан байдаг. Ийм тохиолдолд давтамж хуваарилалтын талаарх баримт нь захиргааны эсвэл бодлогын удирдамж байна.

2006 онд BBC World Service Trust байгууллагын эрхлэн гаргасан Африкийн хэвлэл мэдээллийн хөгжлийн санаачилга (*African Media Development Initiative*)-д эрх зүйн олон талт бүтцийн талаар өгүүлжээ. Судалгаа явуулсан 17 орноос зөвхөн Өмнөд Африк хүйн радио, телевизийн хараат бус тусгай зөвшөөрөл олгох хууль тогтоомж байдаг. Ардчилсан Конго улсад хуулийн ийм зүйл заалт боловсруулах шатандаа байгаа. Өөр 5 улсад эрх зүйн орчин байхгүй байхад, нөгөө 10 оронд хүйн дэс дараатай бодлогын заалт байгаа эсвэл хэвлэл мэдээллийг хуулиар хүлээн зөвшөөрсөн боловч тэдэнд бараг дэмжлэг үзүүлдэггүй.

Радио давтамж хуваарилах асуудал мөн улс болгонд өөр байдаг. Тусгай зөвшөөрлийг тендер явуулсны үндсэн дээр олгох ба хүсэлт гаргагч тодорхой шаардлага биелүүлэх чадвар эсвэл дуудлага худалдаагаар хамгийн их мөнгө төлсөн эсэхийг харгалзана. Дуудлага худалдаа нь санхүүгийн өндөр чадвартай нэгэнд боломж олгодог тул олон ургальч хэвлэл мэдээллийн хөгжилд таагүй нөлөө үзүүлдэг.

Хүйн радио нь эрх зүйн статустай бол, хяналт тавигдаж, эмэгтэйчүүд, үндэстний цөөнх зэрэг нийгмээс тусгаарлагдсан давхаргын хяналтанд, тэдний хэрэгцээ шаардлагад үйлчлэх хүйн өргөн нэвтрүүлэгчдэд долгион хуваарилахыг төрөөс дэмжинэ. Үүнийг тодорхой зорилтот бүлэг эсвэл квот тогтоосны үндсэн дээр явуулна.

Хүйн сонин хэвлэл бол эрүүл хэвлэл мэдээллийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг мөн. Төр, иргэний нийгмийн байгууллагууд чадавхи бий болгоход туслах, төрийн үйлчилгээ эсвэл санхүүгийн байгууллагуудаас шууд бус дэмжлэг үзүүлэх замаар хүйн хэвлэл мэдээллийн хөгжилд нэмэр болох боломжтой. (Media Development and Diversity Agency in South Africa – www.mdda.org.za). Шинээр зөвшөөрөл авахад эхлэлийн хураамж өндөр эсвэл зар сурталчилгаанаас олсон орлогоос шимтгэл авах зэрэг нь хүйн сонин хэвлэлийн хүчийг сулруулж болно. Ерөнхийдөө, олон нийтийн, хүйн, хувийн хэвлэл мэдээллийн олон талт холимог бүтцийг эрх зүй, санхүү, захиргааны журам, хүйн хэвлэл мэдээллийг дэмжсэн тодорхой зүйл заалтаар, харин өргөн нэвтрүүлгийн салбарт – давтамжийн шударга, эрх тэгш хуваарилалтаар бий болгож болно

Хэвлэл мэдээллийн тэнцвэртэй орчинтой холбоотой нийгмийн байгууллын хүрээг баримтжуулах шаардлагатай. Давтамжийн талаарх дотоодын төлөвлөгөөг интернетээс эсвэл дотоодын зохицуулагч байгууллагын цахим хуудаснаас хялбар олж болно.

Гэвч нийгмийн байгууллын тогтолцоог юунд ашиглах талаарх мэдээ олоход хэцүү байх магадлалтай.

Тодорхойлолтын асуудал нь үнэлгээ хийхэд бэрхшээл учруулж болно. “Хүйн” гэх тодотголтой хэвлэл мэдээлэл нь зарим оронд хувийн эсвэл төр засаг эсвэл арилжааны ашиг сонирхолд хөтлөгдсөн байх жишээтэй. Эсрэгээрээ, албан ёсны зөвшөөрөлгүй хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгэмд үр ашигтай үйл ажиллагаа явуулдаг ч хэвлэл мэдээллийн талаарх судалгаанд дурьддаггүй.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.3 ОЛОН НИЙТИЙН, ХУВИЙН, ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОЛОН ТАЛТ ХОЛИМОГ БҮТЦИЙГ ТӨРИЙН ЗҮГЭЭС ТУУШТАЙ ДЭМЖДЭГ

олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээлэлд төрийн зүгээс мэдээлэл өгөхөд ялгавартай ханддаггүй
өргөн нэвтрүүлгийн зохицуулалт нь тоон өргөн нэвтрүүлгийг хамардаг бол, олон нийтэд үйлчлэх станцуудад автоматаар тоон өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгодог
төр засаг шинээр байгуулагдаж буй хэвлэл мэдээлэлд бизнесийн үйл ажиллагааны бүртгэлийн стандарт шаардлагаас бусдаар эхлэлийн хураамж авах эсвэл бусад хязгаарлалт хийдэггүй

Нотлох аргууд

- олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамж хуваарилах тухай зохицуулагч байгууллагын албан ёсны мэдэгдэл, цахим хуудас (хүйн өргөн нэвтрүүлэгчдэд тогтоосон тодорхой хувь хэмжээ эсвэл зорилт төлөвлөгөө зэргийг оролцуулна)
- радио давтамж, суваг, долгион, шугам хуваарилах талаар олонд мэдээлсэн дотоодын төлөвлөгөө
- итгэл даахуйц байгууллагын тайлан, хэвлэл мэдээллийн тэнцвэртэй орчин бүрдүүлэх эрх зүй, бусад заалт, түүнчлэн хүй олонд тулгуурласан сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийг дэмжих талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ
- эдгээр заалтын хэрэгжилтийн тухай, тухайлбал тусгай зөвшөөрөл олгох, төлбөрт зар сурталчилгаа зэрэг улсын нөөцийн хуваарилалт, бодит амьдрал дээр мэдээлэл авах эрхийг дээдэлж буй эсэхэд хяналт шинжилгээ хийх замаар баримт цуглуулах

2.4 ХАРААТ БУС, ИЛ ТОД ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

зохицуулалтын тогтолцоо нь олон ургальч хэвлэл мэдээлэл, тэр дундаа хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамжийн эрх тэгш хуваарилалт хийдэг олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамж хуваарилах талаар шийдвэр гаргах явц нь нээлттэй, оролцоонд тулгуурласан байдаг олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамж хуваарилах талаар шийдвэр гаргах явцыг улс төр, арилжааны нөлөөнөөс ангид байгууллага ажиглах буюу бусад сонирхогч тал хянадаг

Нотлох аргууд

- радио давтамж, суваг, долгион, шугам хуваарилах талаар олонд мэдээлсэн дотоодын төлөвлөгөө
- олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамж хуваарилах тухай зохицуулагч байгууллагын албан ёсны мэдэгдэл, цахим хуудас (хүйн өргөн нэвтрүүлэгчдэд тодорхой тогтоосон хувь хэмжээ буюу зорилт төлөвлөгөө зэргийг оролцуулна)
- зохицуулалтын үйл ажиллагааны хараат бус, ил тод байдлын тухай итгэл даахуйц байгууллагын тайлан

2.5 ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХӨГЖЛИЙГ ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗҮГЭЭС ИДЭВХТЭЙ ДЭМЖДЭГ

хүйн хэвлэл мэдээллийн хувьд өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл авахад үнийн саад тотгор байдаггүй
хүйн өргөн нэвтрүүлэгчдэд радио давтамжийн тодорхой хувь хэмжээ нөөцөлдөг хүй олонд хүйн өргөн нэвтрүүлэг эрхлэх эрх олгох, тогтмол хугацааны дараа уг эрхийг шинэчлэх талаар олон нийтийн сонсгол явуулах зэрэг механизмтай давтамж, кабель, харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн худалдаанаас олох орлогын хувиас хүйн хэвлэл мэдээлэлд хуваарилдаг
төрөөс хөнгөлөлттэй, багасгасан үнэ тариф тогтоох зэргээр хүйн сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийг дэмжихэд нааштай арга хэмжээ авдаг
иргэний нийгмийн байгууллага нь хүйн сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн чадавхи бий болгох, эхлэлийн болоод онцгой үеийн санхүүжилт олгох, эрх ашиг хамгаалах замаар дэмжлэг үзүүлдэг (Association of Independent Publishers in South Africa – www.independentpublisher.org)

Нотлох аргууд

- хүй олонд суурилсан хэвлэл мэдээллийн хөгжил цэцэглэлт, уналтын тухай баримт, тухайлбал шинээр байгуулагдсан хүйн хэвлэл мэдээлэл их хэмжээний доройтол амссан эсэх, хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо өссөн буурсан эсэх, хүйн сонин хэвлэлийн хэвлэгдэх тоо, хамрах хүрээ
- хүйн хэвлэл мэдээлэлд оруулах төр засгийн хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт бууралт
- хүйн өргөн нэвтрүүлэгчдэд давтамж хуваарилалтын хувь хэмжээ, ногдол байгаа эсэх

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation*, March 2002: www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf

BBC World Service Trust, *African Media Development Initiative* (2006):

www.bbc.co.uk/worldservice/trust/specials/1552_trust_amdi/index.shtml

Commonwealth Press Union (CPU): www.cpu.org.uk

European Platform of Regulatory Authorities (EPRA):

www.epra.org/content/english/index2.html

EPRA – international directory of regulatory authorities:

www.epra.org/content/english/authorities/regulation.html

European Telecommunications Standards Institute: www.etsi.org/regulateonline.org: World Dialogue on Regulation for Network Economies – information and resources on regulatory reform, including pro-poor initiatives: www.regulateonline.org/index.php

UNESCO and the Commonwealth Broadcasting Association, *Guidelines for Broadcasting*

Regulation, by Eve Salomon, 2006: http://portal.unesco.org/ci/en/files/21345/11399384219Guidelines_for_Broadcasting_Regulation.pdf/Guidelines+for+Broadcasting+Regulation.pdf

UNESCO, *Legislation on Community Radio Broadcasting: comparative study of the legislation of 13 countries*, 2003: <http://unesdoc.unesco.org/images/0013/001309/130970e.pdf>

World Association of Community Radio Broadcasters (AMARC): <http://www.amarc.org> World Summit on the Information Society: www.itu.int/wsis/search/index.html

С. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДАВТАМЖ ХУВААРИЛАЛТ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Тусгай зөвшөөрөл, давтамж хуваарилалт нь хэвлэл мэдээллийн бүхий орчны үндсэн тодорхойлогч хүчин зүйл учраас эдгээр асуудлын талаарх тус бүлэгт олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээллийн олон талт бүтцийг хангах тухай өмнөх бүлэгтэй агуулга нэг. Тиймээс, дээр өгүүлсэн сэдэв нь энэ ангилалд мөн хамаарна. Тусгай зөвшөөрөл нь олон талт байдалд хүрэх арга бөгөөд өргөн нэвтрүүлэг эрхлэгч байгууллагад тусгай зөвшөөрөл олгохдоо уг асуудлыг харгалзан үзэх нь зүйтэй.

Олон талт өргөн нэвтрүүлэгчдэд тусгай зөвшөөрөл олгохдоо шударгаар хандах нь чухлаас гадна өрсөлдөөнд ашиглах давтамжийн хэмжээтэй харьцуулахад өргөн нэвтрүүлэгт зориулж хангалттай давтамж хуваарилахыг тэргүүн эгнээнд анхаарах нь чухал. Зах зээлийн журмаар ажиллах харилцаа, холбооны салбарынхан илүү ашиг олох боломжтой бөгөөд ихэнхдээ өргөн нэвтрүүлэгчдээс илүү гарч тэднийг хохироодог.

Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) нь радио давтамжийг үр нөлөөтэй ашиглахад зориулж бүх нийтийн тогтолцоо бий болгосон. Энэ нь давтамж хуваарилалтын удирдлагын хэм хэмжээ тогтоож, хуваарилалтын бүх нийтийн тогтолцоог удирддаг. Улс оронд давтамжийн үр ашигтай хэрэглээг хангахын тулд үндэсний төлөвлөгөө боловсруулахдаа Олон улсын цахилгаан холбооны байгууллагын дүрэм журмыг дагаж мөрдөх нь зүйтэй.

19-р зүйл байгууллагын Эфирийн хүртээмж (*Access to the Airwaves*) гарын авлагад тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой сайн туршлагуудын талаар өгүүлжээ. Уг байгууллагаас эрхлэн гаргасан Африкийн зохицуулагчдад зориулсан “Өргөн нэвтрүүлгийн олон ургальч, олон талт байдал” сургалтын гарын авлагад өгөгдөхүүнийг тоон хэлбэрт хувиргах, өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны нийлэмжтэй холбоотой ашигтай санаа тусгагдсан байна.

Мэдээллийн тоон шинэ хэлбэрийн хөгжил, мэдээллийг олон хэлбэрээр түгээх боломж зэрэг хоорондоо уялдаатай үзэгдлүүд нь аналог үеэс үүдэлтэй өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын уламжлалт хэлбэрт уриалан дуудсан. Гэсэн ч, ихэнх өргөн нэвтрүүлэг аналог эсвэл “газрын” дохио хэрэглэж байгаа дэлхийн ихэнх хэсэг тоон хэлбэрт шилжээгүй гэдгийг тэмдэглэвэл зохино. Өгөгдөхүүнийг тоон хэлбэрт хувиргах нь харьцангуй өргөн давтамж үүсгэх боломж олгодог хэдий ч, олон нийтийн мэдээллийн тэнцвэртэй хүртээмж, өмчлөл, агуулгын олон талт байдлыг хангахын тулд өргөн нэвтрүүлгийн зохицуулалт шаардлагатай хэвээр байна.

Бусад ангиллын нэгэн адил, нийгмийн байгууллын хүрээ болон улс төр зонхилсон соёлын хооронд ялгаа зааг гаргах нь зүйтэй.

Зарим улс оронд, хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн журам, зохицуулагч байгуулага бий боловч бодит байдал дээр эдгээр нь улс төр, арилжааны нөлөөлөл, улс төрийн зориг дутагдах, нийгмийн байгууллын чадавхи байхгүй, эсвэл эдгээр хүчин зүйлийн нэгдлээс болж үйлчилдэггүй.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.6 ДАВТАМЖ ХУВААРИЛАЛТЫН ТӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ОЛОН НИЙТИЙН ЭРХ АШИГТ НИЙЦДЭГ

зохицуулах эрх мэдэл бүхий байгууллага олон нийтийн үйлчилгээний өргөн нэвтрүүлэгтэй холбоотой заалтын тухай Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) дүрэм журам, ЮНЕСКО-гийн санал зөвлөмжүүдэд нийцсэн давтамж хуваарилалтын төлөвлөгөөтэй төлөвлөгөөг иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн салбартай зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулдаг төлөвлөгөөг нийтлэх бөгөөд олонд түгээдэг

Нотлох аргууд

- радио давтамж, суваг, шугам хуваарилалтын тухай олонд мэдээлсэн дотоодын төлөвлөгөө
- өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийн заалт, түүнчлэн шийдвэр гаргах нөхцөл, хугацаа, төлбөрийн тухай олонд мэдээлсэн
- тусгай зөвшөөрөл, давтамж хуваарилалтын хэрэгжилтийн талаарх итгэл даахуйц байгууллагын тайлан

2.7 ДАВТАМЖ ХУВААРИЛАЛТЫН ТӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ ӨМЧЛӨЛ,

АГУУЛГЫН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ДЭМЖДЭГ

олон нийтийн, хувийн, хүйн өргөн нэвтрүүлэгчдийн дунд болон дотоодын, бүсийн, орон нутгийн өргөн нэвтрүүлэгчдэд өргөн нэвтрүүлгийн давтамж шударга хуваарилалтыг уг төлөвлөгөөгөөр хэрэгжүүлдэг
олон нийтийн ашиг сонирхлыг хүсэлт гаргагч бусад этгээд илүү сайн хангаж байгаа тохиолдолд давтамжийг дуудлага худалдаагаар илүү үнээр өөр этгээдэд хуваарилдаггүй
аливаа ногдол ашгаас эргээд өргөн нэвтрүүлэгт хуваарилдаг, өөрөөр хэлбэл бүх шинэ давтамжийг өндөр үнээр худалддаггүй
сансарын холбоо, кабелийн нэвтрүүлэг эрхлэгчид заавал биелүүлэх үүрэг хүлээдэг, тухайлбал санал болгож буй сонголтуудын дунд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн суваг оруулах, мөн цөөнхийн суваг зэрэг олон талт байдлыг дэмждэг

Нотлох аргууд

- радио давтамж, суваг, шугам хуваарилалтын тухай олонд мэдээлсэн дотоодын төлөвлөгөө
- тусгай зөвшөөрөл, давтамж хуваарилалтын хэрэгжилтийн талаарх итгэл даахуйц байгууллагуудын нотолгоо
- тусгай зөвшөөрөл олголтод ялгаварлан гадуурхалт буй тухай баримт, тухайлбал тодорхой бүлгүүдийг шашин шүтлэг, хэл яриа, угсаа гарлаар ялгаварлан гадуурхах
- хүй олонд суурилсан хэвлэл мэдээллийн хөгжил цэцэглэлт, уналтын тухай баримт, тухайлбал шинээр байгуулагдсан хүйн хэвлэл мэдээлэл их хэмжээний доройтол амссан эсэх, тусгай зөвшөөрөлгүй хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хариуцлага ногдуулдаг эсэх

2.8 ХАРААТ БУС, ИЛ ТОД ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн явцыг хараат бус, олон улсын стандартад нийцсэн бүрэн эрхт зохицуулагч байгууллага хянадаг
(Зохицуулалтын тогтолцоо 1.В хэсгийг харах)
өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хуульд заагдсан ил тод, бодит шалгуураар үнэлдэг
төрөл бүрийн тусгай зөвшөөрлийн үнэ тариф нь ил тод бөгөөд урьдчилан тогтоогдсон байна
бодит хэрэглээ нь тусгай зөвшөөрлийн нөхцөлтэй нийцэж буй эсэхийг шалгахын тулд зохицуулагчид давтамж ашиглалтыг тууштай хянадаг

Нотлох аргууд

- зохицуулагч байгууллагуудын статус, тэдний төр, арилжааны ашиг сонирхлоос хараат бус байдлын тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олголт, олгох нөхцөл, шийдвэр гаргах хугацаа, үнэ тарифийн тухай хуулийн заалт
- тусгай зөвшөөрөл, давтамж хуваарилалтын хэрэгжилтийн тухай итгэл даахуйц байгууллагын тайлан

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation*, March 2002: www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf

Article 19, *Broadcasting Pluralism and Diversity: Training Manual for African Regulators*, June 2006: www.article19.org/pdfs/tools/broadcasting-manual.pdf

Article 19, *Broadcasting Policy and Practice in Africa*, 2003:

www.article19.org/pdfs/publications/africa-broadcasting-policy.pdf

European Platform of Regulatory Authorities – international directory of regulatory authorities: www.epra.org/content/english/authorities/regulation.html

International Telecommunications Union – Radiocommunications Sector:

www.itu.int/ITU-R/

Media Institute of Southern Africa: *Licensing and Accreditation – the threat to media freedom in the SADC region*: www.misa.org/publications/Protocol%20Sadc.pdf

World Association of Community Radio Broadcasters (AMARC): <http://www.amarc.org>

D. ТАТВАР, БИЗНЕСИЙН ЗОХИЦУУЛАЛТ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Татвар, бизнесийн зохицуулалт нь хэвлэл мэдээллийн хөгжилд саад тотгор болох эсвэл түүнийг дэмждэг тул эдгээр асуудлыг авч үзэв. Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, мөн хүйн хэвлэл мэдээлэлд дотоодын аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бүхий л хууль тогтоомж, зохицуулалтаар, тэр дундаа татвар, импортын хураамж, бүртгэлийн хураамж, журам, ажлын байрны шаардлага зэрэгтэй холбоотой дүрэм журмаар эрх тэгш хандах ёстой.

Хэвлэх машин зэрэг хэвлэлийн тоног төхөөрөмж эсвэл цаас гэх мэт хэрэглээний зүйлс, сонин хэвлэлийн борлуулалтаас хураах татвар зэрэг татварын тодорхой бодлого нь хэвлэл

мэдээллийн хөгжилд саад болдог. Төр засгаас татвар, хураамж ногдуулахдаа шилж сонгох нь хэвлэлийн зах зээлийг гажуудуулж, төрийн хяналтанд байдаг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд таатай нөхцөл бүрдүүлдэг.

Төр засгаас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд татвар, импортын хураамж, үнийн, мөн тоног төхөөрөмж /радио, телевиз, компьютер, зөөврийн төхөөрөмж зэрэг/ худалдан авахад хөнгөлөлт эдлүүлэх зэргээр хэвлэл мэдээллийн хөгжил цэцэглэлтэд дэмжлэг үзүүлж болно. Мөн өргөн нэвтрүүлэгчдээс шууд татвар авахгүй байх, эсвэл багасгаж болно.

Үл ялгаварлах зарчим хамгийн чухал зүйл юм. Төр засаг, улс төрийн буюу арилжааны аливаа ашиг сонирхлоос үүдэн тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг бусдаас илүүд үзэж болох татварын эсвэл арилжааны зохицуулалтын арга хэрэглэх ёсгүй.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.9 ТӨР ЗАСГААС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХӨГЖЛИЙГ ҮЛ ЯЛГАВАРЛАХ БАЙДЛААР ДЭМЖИХ ТАТВАР, САНХҮҮГИЙН БОДЛОГО ЯВУУЛДАГ

сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих татварын хөнгөлөлт, импортын татвар, үнийн дэглэмтэй төр, хэвлэл мэдээллийн байгууллагад өндөр татвар ногдлуулдаггүй төрийн татварын тогтолцоо нь хэвлэл мэдээллийг ялгаварладаггүй, тодорхой хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг бусдаас илүүд үздэггүй

Нотлох аргууд

- дотоодын зохицуулагч байгууллага, татварын албадын албан ёсны тайлан буюу цахим хуудас
- хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжихтэй холбоотой татварын бодлогыг хэрэгжүүлдэг тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- татварын тогтолцооны хэрэгжилт, ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг үл ялгаварлах, хэвлэл мэдээллийн салбарыг хохироохуйц өндөр татвар ногдуулдаг тухай итгэл даахуйц байгууллагын тайлан

Е. ЗАР СУРТАЛЧИЛГАА

Төр засгийн зар сурталчилгаа байршуулах нь хэвлэл мэдээллийн олон ургальч байдал, хөгжлийг сааруулах эсвэл дэмжих боломжтой. Зар сурталчилгааны агуулгатай холбоотой зохицуулалтыг энэ бүлгээр нарийвчлан авч үзэх зорилгогүй болно. Улсын төсөвт зар

сурталчилгаа нь арилжааны зар сурталчилгааны зах зээл тааруу хөгжсөн улс орнуудад орлогын гол эх үүсвэр нь болдог.

Үл ялгаварлах зарчим хамгийн чухал зүйл мөн. Төр засаг, улс төрийн буюу арилжааны аливаа ашиг сонирхлын үүднээс зар сурталчилгааг зарим тодорхой хэвлэл мэдээллийн хэрэгслийг бусдаас ялгаварлах хэрэгсэл болгон ашиглах ёсгүй. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчид зар сурталчилгаанд зах зээлийн үнээс доогуур үнэ санал болгож, өөрсдийн өрсөлдөгчтэй шударга бусаар өрсөлдөж болохгүй.

Нэвтрүүлэг, хөтөлбөрийн чанарын ашиг сонирхолын үүднээс улсаас зар сурталчилгааны ерөнхий хэмжээг хязгаарлаж болно. Гэхдээ, уг хязгаарлалтууд нь хэвлэл мэдээллийн салбарын өсөлтөд нөлөөлөхгүйгээр үл барам, хэвлэл мэдээллийн аль нэг салбарыг шударга бусаар ашиггүй байдалд оруулж болохгүй. Хил дундын телевизийн тухай Европын конвенц /European Convention on Transfrontier Television/ зэрэг бүс нутгийн тхэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарлалтуудыг гарын авлага болгон ашиглаж болно.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.10 ТӨРӨӨС ТАТВАРЫН БОДЛОГООР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХДАГГҮЙ

**төрөөс зар сурталчилгааг шударга, ил тод, үл ялгаварлах байдлаар, өөрөөр хэлбэл ёс зүйн кодын дагуу байрлуулдаг
бүх хэвлэл мэдээллийн шударга хүртээмжийг хангахын тулд төр засгийн зар сурталчилгааны хуваарилалтыг нягт хянадаг
олон нийтийн үйлчилгээний өргөн нэвтрүүлэгчид өөрсдийн явуулж буй зар сурталчилгааны хүрээнд шударга өрсөлдөөний дүрэм баримтлах үүрэг хүлээдэг
улсын төсөвт зар сурталчилгаа хуваарилалтын хэрэгжилт нь ёс зүйн код буюу бусад удирдамж баримталдаг**

2.11 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ҮР ДҮНТЭЙ ЗОХИЦУУЛАЛТТАЙ

**өргөн нэвтрүүлэгчид, сонин хэвлэл үндэсний эсвэл бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зар сурталчилгааны агуулгын хязгаарлалтуудыг дагаж мөрддөг
өргөн нэвтрүүлэгчид, сонин хэвлэл үндэсний буюу бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зар сурталчилгаа, хөтөлбөрийн тусгаарлалтын удирдамжийг дагаж мөрддөг
зар сурталчилгааны төөрөгдлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий мэргэжлийн хараат бус байгууллагын боловсруулсан зар сурталчилгааны ёс зүйн**

КОДТОЙ

Нотлох аргууд

- зар сурталчилгааны ёс зүйн кодтой ба түүнийг дагаж мөрддөг
- зар сурталчилгааны агуулгын хэмжээний тухай удирдамж, зар сурталчилгаа, хөтөлбөрийн тусгаарлалт байдаг ба түүнийг дагаж мөрддөг

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19, *Access to the Airwaves: Principles on Freedom of Expression and Broadcast Regulation*, March 2002:

www.article19.org/pdfs/standards/accessairwaves.pdf

Article 19, *Broadcasting Policy and Practice in Africa*, 2003:

www.article19.org/pdfs/publications/africa-broadcasting-policy.pdf

BBC World Service Trust, *African Media Development Initiative* (2006):

www.bbc.co.uk/worldservice/trust/specials/1552_trust_amdi/index.shtml

EPRA – international directory of regulatory authorities:

www.epra.org/content/english/authorities/regulation.html

European Convention of Transfrontier Television:

<http://conventions.coe.int/Treaty/EN/treaties/Html/132.htm>

UNESCO and the Commonwealth Broadcasting Association, *Guidelines for Broadcasting Regulation*, by Eve Salomon, 2006: http://portal.unesco.org/ci/en/files/21345/11399384219Guidelines_for_Broadcasting_Regulation.pdf

http://portal.unesco.org/ci/en/files/21345/11399384219Guidelines_for_Broadcasting_Regulation.pdf

[Guidelines+for+Broadcasting+Regulation.pdf](http://portal.unesco.org/ci/en/files/21345/11399384219Guidelines_for_Broadcasting_Regulation.pdf)

Ангилал 3. Хэвлэл мэдээлэл ардчилсан яриа хэлэлцүүлгийн талбар болох нь

А. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ НИЙГМИЙН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ИЛЭРХИЙЛНЭ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хэвлэл мэдээлэл нь ардчилал, сайн засаглалын тогтвортой байдлыг ханган, хөгжүүлж, хүний эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч энэ үүргээ хэрхэн биелүүлдэг тухай ойлголт хомс байдаг. Эдгээрийг тойрсон хурц асуудлын нэг бол хэвлэл мэдээлэл нь давхардмал өгөөд өөр өөр үүрэгтэй. Нэг талаасаа хэвлэл мэдээлэл бол ардчилсан яриа хэлэлцүүлэг өрнөх, мэдээлэл солилцох, соёлын илэрхийллийн талбар болдог. Харин нөгөөтэйгүүр, өөрийн эрхийн хүрээнд эрх мэдэл

бүхий төрийн, хувийн нийгмийн байгууллын “хоточ нохой” болж, төр засгийн үүрэг хариуцлагыг хянаж байдаг нийгмийн оролцогч байдаг. Нийгмийн идэвхтэй оролцогчийн хувьд хэвлэл мэдээлэл нь мөн улс төрийн тодорхой эрх ашгийг хамгаалж, зөрчилдөөний хэрэгсэл болж болно. Энэ чинээгээрээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бусад ямар ч нийгмийн оролцогчийн хувьд өөрийн үйлдлийн төлөө хариуцлагатай байх ёстой гэдэг нь ойлгомжтой. Гэсэн ч, хэлэлцүүлэг мэтгэлцээн өрнөдөг талбарын хувьд хэвлэл мэдээлэлд эдгээрийг өрнүүлэх, мэдээлэл дамжуулахад улс төрийн нам эсвэл засгийн газраас хяналт тавихгүй байх нь чухал. Ийм учраас нийт хэвлэл мэдээллийн салбарынхны зүгээс тэднийг хариуцлагатай байх үүднээс зохицуулах гэсэн оролдлогыг эсэргүүцэж, ийм учраас төрийн зохицуулалтаар сонин хэвлэл болон өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн үүрэг хариуцлагыг хооронд нь ялгаж зааглан, олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд ардчиллын онцгой үүрэг ногдуулдаг байна.

Гэвч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ардчилсан нөөц бололцоогоо хэрэгжүүлэхийн тулд нийгмийн олон талт байдлыг тусгах гэсэн шаардлага нь зөв юм. Нийгмийн олон талт байдал нь жендер, нас, арьс өнгө, угсаа, хэл, шашин шүтлэг, бие махбодийн чадвар, бэлгийн чиг баримжаа, орлого, нийгмийн анги давхарга зэрэг олон талтай. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгмийн олон талт туршлага бүрэлдүүлэх хангалттай чадвартай. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн аль ч давхаргын санаа зовоож буй асуудлыг дамжуулан мэдээлэх боломжтой бөгөөд мэдээлэл, зугаа цэнгээний хөтөлбөрийг янз бүрийн давхаргуудад хүргэдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн нийгмийн давхарга бүрийн өөрсдийгөө илэрхийлэх, дуу хоолойгоо сонсгох боломжоор хангадаг. Гэвч хэвлэл мэдээлэл нь хэвшмэл үзлийг бэхжүүлэх, нийгмийн давхаргуудын хоорондын сөргөлдөөнийг дэвэргэх, аль нэгэн давхаргыг олон нийтийн яриа хэлэлцүүлэгт оруулахгүй байх замаар нийгмийн хардлага сэрдлэг, айдас, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл бий болгож болно.

Олон ургальч хэвлэл мэдээлэл нь олон талт байдалд хүрэх цорын ганц нөхцөл биш юм. Хүйн хэвлэл мэдээлэл үндэстний цөөнх эсвэл нийгмээс тусгаарлагдсан давхаргад үйлчлэх онцгой үүрэгтэй бөгөөд түүнийг төр, иргэний нийгэм дэмжих нь хэвлэл мэдээлэл нийгмийн олон талт байдлыг хангахад амин чухал үүрэгтэй. (Ангилал 2-ыг харна уу). Гэсэн хэдий ч, үндэстний цөөнхийн асуудлыг гол хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тусгах нь багагүй ач холбогдолтой. Хэвлэл мэдээлэл нийгмийн олон талт байдлыг тусгахад мөн албан ёсны зохицуулалт шаардлагатай. Өөрөөр хэлбэл, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн нийгмийн бүх давхаргад үйлчлэх, улс төрийн нам, эвсэлд ижил тэнцүү, шударга хандахыг шаардах. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг үзэн ядалтаас үүдсэн үг хэллэгийг хориглосон зүйл заалт оруулах зэргээр иргэний эсвэл эрүүгийн хуулиар зохицуулж болно.

Арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчид нь давамгайл байдлаар зар сурталчилгааны эздийн эрх ашигт нийцүүлэн хүн ам төвлөрсөн хэсэгт чиглэгдэх нийгэмд зохицуулалт онц шаардлагатай. Ийм нөхцөлд олон нийт болон хүн хэвлэл мэдээлэл ядуучууд буюу алслагдсан эсвэл хөдөөний хүн ардын мэдээллийн хэрэгцээнд нийцүүлэх нь нэн чухал.

Хэвлэл мэдээллийн олон талт байдал, цаашилбал өөрийн зохицуулалт, тэнцүү хараа хяналт, үзэгч сонсогчдын хариу үйлдэл зэрэг зохион байгуулалттай соёлоос хамааралтай. Шинэ технологи газар авч буй нь блог, иргэдийн мэдээлэл, хэрэглэгчээр удирдуулан агуулга болон хэрэглэгчдийн хэвлэл мэдээлэлд шууд оролцох бусад хэлбэрээр нийгмийн олон талт байдал илэрхийллээ улам ихээр олж байна.

Хэвлэл мэдээллийн олон талт байдлыг төлөөлөх чадвар нь эмэгтэй эсвэл үндэстний цөөнх сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн удирдах ажилтнуудын хувь тэнцүү байдлаас мөн хамаардаг.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1 ОЛОН НИЙТИЙН, ХУВИЙН, ХҮЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛҮҮД НИЙГМИЙН БҮХ ДАВХАРГЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД ҮЙЛЧИЛДЭГ

хэвлэл мэдээлэл нь зорилтот нутаг дэвсгэрт хэл шинжлэлийн олон талт байдлыг тусгасан хэл дээр дамжуулдаг

хэвлэл мэдээлэл нь нийгмээс тусгаарлагдсан давхаргад түшиглэсэн хэл ашигладаг

хүйн сонин хэвлэл, өргөн нэвтрүүлэг уугуул, омгийн, цагаач зэрэг тодорхой бүлгүүдэд зориулж бүтээл хийдэг

төрийн буюу олон нийтийн хэвлэл мэдээлэл нь бодит байдал дээр улс төрийн бүхий л цар хүрээний үзэл бодол, нийгмийн ашиг сонирхлын өргөн цар хүрээ, түүнчлэн нийгмийн эмзэг хэсгүүдийг төлөөлдөг

хэвлэл мэдээллээр цацагдаж буй мэдээлэл нь эмэгтэйчүүд, нийгмээс тусгаарлагдсан давхаргад хүртээмжтэй байх, өөрөөр хэлбэл эдгээр бүлгүүд хэрхэн мэдээлэл авдаг, бичиг үсэгт тайлагдсан зэрэг байдлыг харгалздаг

Нотлох аргууд

- олон нийтийн өргөн нэвтрүүлгийн агуулгын тодорхой хувь үндэстний цөөнхийн хэл дээр нэвтрүүлэх буюу нийгмээс тусгаарлагдсан давхаргад зориулагдсан
- үндэстний цөөнхийн хэл дээр нэвтрүүлэх буюу нийгмээс тусгаарлагдсан давхаргад үйлчлэх хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо болон хамрах хүрээ (үзэгч

сонсогчдын тоо)

- хэвлэл мэдээлэл, түүнчлэн олон талт байдлын агуулгад итгэл даахуйц байгууллагын хараат бус дүн шинжилгээ

3.2 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД АЖИЛ ОЛГОХДОО НИЙГМИЙН ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ТУСГАДАГ

хэвлэл мэдээллийн салбарт, тэр дундаа удирдах албан тушаалд эмэгтэй сэтгүүлчдийн төлөөлөл шударга байдаг

хэвлэл мэдээллийн салбарт, тэр дундаа удирдах албан тушаалд үндэстний цөөнх, хэл яриа, шашны бүлгүүдийн сэтгүүлчдийн төлөөлөл шударга байдаг

Нотлох аргууд

- эмэгтэй сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн эмэгтэй удирдах албан тушаалтнуудын тоон харьцаа
- үндэстний цөөнх, хэл яриа, шашны бүлгүүдийн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн удирдах албан тушаалтнуудын тоон харьцаа

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19, *Broadcasting Pluralism and Diversity: Training Manual for African Regulators*, 2006: www.article19.org/pdfs/tools/broadcasting-manual.pdf

Commonwealth Broadcasting Association (CBA) with support from UNESCO, *CBA Editorial Guidelines*, 2005 (<http://unesdoc.unesco.org/images/0013/001356/135672e.pdf>)

European Monitoring Centre on Racism and Xenophobia:

www.eumc.eu.int/eumc/index.php

Global Media Monitoring Project – relating to portrayal and involvement of women in the media: www.whomakesthenews.org

International Federation of Journalists – EU-India gender project:

www.ifj.org/default.asp?Issue=Gender%20india&Language=EN

International Media Working Group against Racism and Xenophobia – diversity-online project:

www.diversity-online.org/

Media Diversity Institute: www.media-diversity.org/ and its Reporting Diversity

Network: www.media-diversity.org/links/rdn.htm

Media Sustainability Index www.irex.org/msi

MediaWise – activities on diversity in the media:

www.presswise.org.uk/display_page.php?id=73

UNESCO Institute for Statistics – Questionnaire on Newspaper Statistics:

www.uis.unesco.org/ev.php?ID=5831_201&ID2=DO_TOPIC
UNESCO Institute for Statistics – Questionnaire on Radio and Television Broadcasting
Statistics: www.uis.unesco.org/ev.php?ID=6554_201&ID2=DO_TOPIC
World Association of Community Radio Broadcasters: www.amarc.org

В. ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗАГВАР

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг олон нийт санхүүжүүлэн, хянаж, тэдний эрх ашигт үйлчилдэг өргөн нэвтрүүлэг хэмээн ойлгоно. Тэрээр арилжааны ч улсын ч өмч биш ба улс төрийн оролцоо, арилжааны хүчний дарамтаас ангид байна. Иргэд түүгээр дамжуулж мэдээлэл авч, боловсрол олж, зугаацаж цэнгэдэг. Олон ургальч, нэвтрүүлгийн олон талт байдал, редакцийн хараат бус байдал, боломжийн санхүүжилт, хариуцлага, ил тод байдал зэрэг нь баталгаажсан олон нийтийн үйлчилгээний өргөн нэвтрүүлэг ардчиллын тулгын чулуу болж чаддаг. (Энэхүү үүргийнх нь талаар 2001 онд Виндхукийн Тунхаглалын 10 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан форумын үеэр баталсан Африкийн өргөн нэвтрүүлгийн дүрмээс харна уу.) Хамгийн чухал нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ төрийн байлаа ч улс төрийн аливаа нам эвслээс ангид, ашгийн бус, олон нийтийн эрх ашигт үйлчилдэг бөгөөд үндэстнийг хамарч, зорилго нь улс орныг хамарсан байх ёстой. Үндэстний хэмжээний үйлчилгээнүүд ихэвчлэн холбооны улсууд эсвэл өөртөө засах муж улс бүхий эсвэл өөр өөр хэл дээр өргөн нэвтрүүлэг цацдаг үйлчилгээ зэрэг бүсийн олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээгээр нөхөгддөг.

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ (ОНӨНҮ) нь ерөнхийдөө хэрэглэгчдээс хураасан татвараас бүрдэх улсын төсвөөс санхүүждэг. ОНӨНҮ нэмэлтээр зарим нэгэн арилжааны санхүүжилт авч болно. Хувийн өмчит өргөн нэвтрүүлэгчид, мөн олон нийтийн үйлчилгээний тодорхой үйл ажиллагаа эрхэлж болдог. ОНӨНҮ нь дотоодын өргөн нэвтрүүлгийн бүх хэрэгцээ шаардлагыг зах зээл хангах боломжгүй гэсэн ойлголтоос үндэстэй. Удирдлага, төсөв болоод редакцийн хараат бус байдлын хувьд арилжааны болон улс төрийн шинжтэй оролцооноос хамгаалагдах нь ОНӨНҮ-ний онцлог юм. Түүний олон нийтийн үйлчилгээ нь олон нийт улс төрийн тэнцвэртэй мэдээлэл, ялангуяа сонгуулийн үеэр хүртэхийг хангаж ажиллахад чиглэгдэнэ.

Түүнчлэн, дамжуулалтын систем нь улс орны бүхий л нутаг дэвсгэрийг хамтарч, бүх бүс нутаг, соёл, хэлний бүлэг давхаргуудад үйлчилгээ хүргэхийг эрмэлздэг. Мэдээж энэ нь хүмүүсийг өргөн нэвтрүүлэг хүлээн авах, тог цахилгаанд холбогдох, харилцаа холбоо хүртэх зэрэг харилцаа холбооны хэрэгслийн хүртээмжтэй байдлыг шаардана. ОНӨНҮ ерөнхийдөө зар сурталчилгааны хязгаарлалттай эсвэл үүнийг явуулдаггүй. ОНӨНҮ-ний

нэвтрүүлгүүд үнэ төлбөргүй эсвэл хүн амын олонхийн төлөх боломж бүхий үнэ тариф тогтоосон байна. ОНӨНҮ эрхлэгчдэд тавих шаардлагад цогц бөгөөд тэнцвэртэй мэдээ дамжуулах, түүнчлэн олон нийтийн нээлттэй мэтгэлцээн явуулах, маш бага хэмжээний орон нутгийн агуулга бүхий мэдээ (квот ашиглах замаар байж болно), бүтээлч, олон талт, өвөрмөц нэвтрүүлэг явуулах.

Зарим өргөн нэвтрүүлэгчид дээрх шинж чанарын бүгдийг нь боловч биш заримыг нь агуулсан байдаг. Тухайлбал, хүйн станцууд үндэстний хэмжээнд цацагдахгүй боловч олон нийтийн үйлчилгээний үүрэг гүйцэтгэдэг.

Олон нийтийн үйлчилгээний өргөн нэвтрүүлэгчид өөрийн орны хэвлэл мэдээллийн технологийг орчин үетэй хөл нийлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд газар зүйн байрлал, нас, боловсрол, хөрөнгө чинээнээс үүдэлтэй тоон хуваагдлын эсрэг тэмцэх зөв зүйтэй арга хэрэглэх шаардлагатай.

Олон нийтийн үйлчилгээний үүргийг тусгай зөвшөөрөл олгогч зохицуулах байгууллагаар дамжуулах зэрэг арга замаар бүх өргөн нэвтрүүлэгчдэд ногдуулж болно.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.3 ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО ХУУЛИАР ТОДОРХОЙЛОГДОЖ, БАТАЛГААЖСАН

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний чиглэлийг хуулиар тодорхойлсон

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь редакцийн хараат бус байдлын баталгаа, хөндлөнгийн оролцооноос хамгаалагдсан зүй зохистой, найдвартай санхүүжилтийн зохицуулалттай

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь техникийн хангалттай нөөцтэй байна

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь өөрийн захиргааны байгууллагаар дамжуулан олон нийтийн өмнө үүрэг хариуцлага хүлээдэг

Нотлох аргууд

- олон нийтийн өргөн нэвтрүүлгийн дамжуулалттай холбоотой аливаа хууль тогтоомж
- нэг буюу түүнээс дээш тооны өргөн нэвтрүүлэгчдийн баримтлах олон нийтийн үйлчилгээний аливаа үүрэг хариуцлага
- редакцийн хараат бус байдал, санхүүгийн зохицуулалт тогтоохыг баталгаажуулсан

аливаа зохицуулалт

3.4 ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ЯМАРЧ БАЙДЛААР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙДАГ

сансарын болон кабелийн сувгийн үйчилгээ эрхлэгчид олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний агуулга, хөтөлбөрийг нэвтрүүлэхээс татгалздаггүй

Нотлох аргууд

— суваг ялгаварлан гадуурхахаас хамгаалсан тодорхой дүрэм журам байгаа эсэх

3.5 УДИРДЛАГЫН ХАРААТ БУС, ИЛ ТОД ТОГТОЛЦОО

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг хуулиар баталгаажсан эрх мэдэл бүхий хараат бус удирдах байгууллага хянадаг

удирдах байгууллагын томилгоо нь нээлттэй, ил тод, төр засгийн шууд нөлөө эсвэл улс төр, эдийн засгийн аливаа ашиг сонирхлын хараа хяналтаас ангид байдаг

удирдах байгууллага нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ олон нийтэд үйлчлэх дамжуулалтыг сахин биелүүлж, хараат бус байдлаа хамгаалахыг хариуцдаг

Нотлох аргууд

- удирдах байгууллагын статус, томилгоотой холбоотой аливаа зохицуулалт
- эрх мэдлээ хэрэгжүүлж буй удирдах байгууллагын тухай баримт

3.6 ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ОЛОН НИЙТ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАДАГ

олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь олон нийт, иргэний нийгмийн байгууллагатай зөвлөлдөж, тэдний оролцоог ханган, санал гомдол хүлээн авах хүсэл эрмэлзэлтэй

удирдах байгууллагын томилгоонд олон нийт оролцдог

Нотлох аргууд

- олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, иргэний нийгмийн хоорондын зөвлөгөөн, түүнчлэн үзэгч сонсогчдын эргэх холбоонд тулгуурласан хэлэлцүүлэг зохион байгуулсан тохиолдлууд
- олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ нь олон нийтийн санал гомдлын дагуу хариу үйлдэл үзүүлсэн тохиолдлууд

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19 International Standards series – A Model Public Service Broadcasting Law, June 2005: www.article19.org/pdfs/standards/modelpsblaw.pdf

Council of Europe, Committee of Ministers, and Recommendation No R (96) 10 of the Committee of Ministers to Member States on the Guarantee of the Independence of Public Service Broadcasting, Sept 11 1996:

www.ebu.ch/CMSimages/en/leg_ref_coe_r96_10_psb_110996_tcm6-4322.pdf

International Federation of Journalists – Public Broadcasting for All campaign and related resources:

www.ifj.org/default.asp?Issue=pubbroad&Language=EN

International Federation of Journalists – international directory of public broadcasters:

www.ifj.org/default.asp?Issue=pubroadlinks&Language=EN

Public Service Broadcasting Trust – India: www.psb.org/index2.htm

Recommendation CM/Rec (2007)3 of the Council of Europe on the remit of public service media in the information society

UNESCO, *Public Service Broadcasting. A Best Practices Source Book*, 2005:

http://portal.unesco.org/ci/en/ev.phpURL_ID=20394&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

UNESCO, Asia-Pacific Institute for Broadcasting Development: *Public Service*

Broadcasting – a comparative legal survey, by Toby Mendel, 2000:

www.unesco.org/webworld/publications/mendel/jaya_index.html

Sample websites for national and regional regulators:

Asia-Pacific: www.abu.org.my

Bosnia-Herzegovina: www.cra.ba

Canada: www.crtc.gc.ca/eng/welcome.htm

Czech Republic: <http://www.rrtv.cz/en/>

Estonia: www.rhn.ee/e_main.htm

Europe: www.epra.org/content/english/index2.html

Europe: www.ebu.ch/en/index.php

Jamaica: www.broadcastingcommission.org

Kenya: www.cck.go.ke/home/index.asp

Kosovo: www.imc-ko.org/index.php?lang=en&pag=home

Nigeria: www.nbc.gov.ng

North America: <http://www.nabanet.com/>

South Africa: www.icasa.org.za/Default.aspx?Page=2

United Kingdom: www.ofcom.org.uk/

С. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Сэтгүүл зүйд ёс зүй, мэргэжлийн өндөр хэм хэмжээг бий болгон, баталгаажуулахын тулд хэвлэл мэдээллийн байгууллагуудын дотор болоод тэдгээрийн хоорондын сайн дурын өөрийн зохицуулалт шаардлагатай.

Үр дүнтэй өөрийн зохицуулалт гэдэг нь агуулга хэлбэр, соёлын аль алинд хамаарах асуудал юм. Үндэстний хэвлэл мэдээллийн соёл нь ёс зүйн код, омбудсмен, өргөдөл гомдол хүлээн авах зөвлөл, залруулга хэвлэн нийтлэх буюу нэвтрүүлэх зэрэг өөрийн зохицуулалтын системтэй байж болох боловч олон нийтийн хараа хяналт хэрэгжихгүйгээр үр дүнгүй болно. Эсрэгээрээ, өөрийн зохицуулалт зарим тохиолдолд эрх барих байгууллагын оролцоогүйгээр үр дүнтэй байж, орон нутаг, дотоодын хэмжээнд, мэдээний ёс зүй, үнэн бодит байдалд хариуцлагатай, ил тод хандсан тохиолдолд хэрэгжих боломжтой. Хэвлэн нийтлэгч, эзэд, редактор, сэтгүүлчид зэрэг хэвлэл мэдээллийн салбарын бүхий л сонирхогч талууд, мөн түүнчлэн өргөн олныг хамарч байж өөрийн зохицуулалт амжилттай хэрэгжинэ. Хэвлэл мэдээллийн байгууллагууд мэргэжлийн ёс зүйн код боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлбэл зохино.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт хөгжөөгүй нөхцөлд санал гомдол, ёс зүйн хөтөч зэрэг гол асуудалд анхаарал хандуулыг чармайх хэрэгтэй. Зохицуулалттай холбоотой мухардмал байдал хэд хэдэн орны өмнө тулгарч байна. Зөрчилдөөн нүүрлэсэн улс орнуудад хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь зөрчилдөөнийг дэврээж, үзэн ядалтыг хөөргөж болох боловч үүнийг төр засгийн зүгээс улс төрийн зорилгоор цагдан хянахгүйн тулд хориглож болохгүй. Ёс зүйн сургалт, хэвлэл мэдээллийн хяналт шинжилгээ хийхэд олон улсын дэмжлэг бүхий өөрийн зохицуулалтыг аль болох боломжоор хэрэгжүүлэх нь зүйтэй. Бүхий л нөхцөл байдалд тохирохуйц нэгдмэл загвар гэж байдаггүй.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.7 СОНИН ХЭВЛЭЛ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН НӨЛӨӨ БҮХИЙ БҮТЭЦТЭЙ

хэвлэл мэдээллийн байгууллага нь ёс зүйн тодорхой кодтой, редакцийн нарийвчилсан чиглэлтэй
уг кодыг сэтгүүлчдэд өргөнөөр түгээсэн ба тогтмол хэлэлцүүлж, эргэн хардаг
хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн стандартын зөрчлийн талаар олон нийтийн санал гомдол хүлээн авах тогтолцоотой
өөрийн зохицуулалтын байгууллага, мэдээний омбудсмен нь төр засаг, арилжааны ашиг сонирхлоос хараат бус

Нотлох аргууд

- хараат бус хэвлэлийн консул буюу сэтгүүлчдийн эвлэлийн үйл ажиллагааны тухай баримт
- ёс зүйн код, түүний идэвхтэй хэрэглээ, хараат бус хэвлэлийн консул эсвэл сэтгүүлчдийн эвлэлээр түгээлгэх
- хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн санал гомдлын тоо, үүнд үзүүлэх хэвлэл мэдээллийн хариу үйлдлийн тухай мэдээлэл

3.8 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН СОЁЛЫГ ИЛЭРХИЙЛДЭГ

сэтгүүлчдийн хараат бус эвлэл үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сайн туршлага нэвтрүүлдэг
хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн санал гомдол хүлээн авах суваг ажиллуулж, хариу өгөх эрхээр хангах зэргээр үзэгч сонсогчдын хандалтад хариу үзүүлдэг
өөрийн зохицуулалтын байгууллагууд иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоонд тулгуурлаж, нийгмийн олон талт гишүүнчлэлээс бүрддэг
хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид өөрийн цензурт автаагүй

Нотлох аргууд

- сэтгүүлчид, олон нийтийн дунд ёс зүй, стандартын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн тохиолдлууд
- сэтгүүлчдийн хараат бус эвлэлийн ёс зүй, стандарттай холбоотой үйл ажиллагааны тухай мэдээлэл

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19, *Freedom of Accountability – Conference Report on Media Self-Regulation in South-East Europe*, Sarajevo, June 2005: www.article19.org/pdfs/conferences/sarajevo-conference-report.pdf

Al-Jazeera Code of Ethics:

<http://english.aljazeera.net/news/archive/archive?ArchiveId=5190>

British Broadcasting Corporation Editorial Guidelines:

www.bbc.co.uk/guidelines/editorialguidelines/

Independent Press Councils – international listing of press councils and related resources: www.media-accountability.org/html/frameset.php?page=directory

Independent Press Councils – international listing of codes of ethics: www.media-accountability.org/html/frameset.php?page=library2

International Federation of Journalists – Declaration of Principles on the Conduct of Journalists: www.ifj.org/default.asp?Issue=ETHICS&Language=EN

International Freedom of Expression exchange – information on journalism ethics: www.ifex.org/en/content/view/full/51725/

International Journalists' Network – international directory of codes of ethics: www.ijnnet.org/Director.aspx?P=Ethics

MediaWise – international listing of journalistic codes of conduct: www.presswise.org.uk/display_page.php?id=40

MediaWise – resources relating to regulation and self-regulation: www.presswise.org.uk/display_page.php?id=708

Organization of News Ombudsmen: www.newsombudsmen.org/what.htm Society of Professional

Journalists (US) – international listing of journalistic codes of ethics: www.spj.org/ethicscode-other.asp

D. ШУДАРГА БАЙХ, ТАЛ ТОХОЙ ТАТАХГҮЙ БАЙХ ШААРДЛАГУУД

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Мэдээллийг шударга болоод тал тохой таталгүй хүргэх эрх зүйн шаардлага улс орон бүрт өөр байдаг. ЮНЕСКО-гийн тунхаглал, олон улсын хэм хэмжээний бусад хөтөч сонин хэвлэл буюу интернет дэх мэдээ, санаа бодлын агуулга хянах шаардлагыг үл зөвшөөрнө. Гэсэн хэдий ч, шударга байдал, ёс зүйг онцолсон зохицуулалт нь голдуу радио, телевизийн тусгай зөвшөөрөл олгох журамд тусгагдсан байдаг. Нэгдсэн вант улсын хуулиар бүх өргөн нэвтрүүлгийн мэдээ, бусад хөтөлбөрүүд маргаантай асуудалд алагчилалгүй, шударга хандахыг шаарддаг.

Өргөн нэвтрүүлгийн ёс зүйн кодоор сонгуулийн үеэр улс төрийн аль ч намд ижил тэгш цаг хуваарилах журам тогтоох шаардлагатай. Сонгууль сурвалжлах жишиг улс орон бүрт өөр өөр байдаг. Гэвч өргөн нэвтрүүлгийн ёс зүйн код нь цензур буюу гадны нөлөөлөлд халхавч болж хэвлэл мэдээллийн редакцийн хараат бус байдалтай зөвшилцөх ёсгүй. Доорх холбоосуудаас ёс зүйн кодын хэд хэдэн загвартай танилцаж болно.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.9 ШУДАРГА, ТАЛ ТОХОЙ ТАТАХГҮЙ БАЙХЫГ ШААРДСАН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮР ДҮН БҮХИЙ КОДТОЙ

өргөн нэвтрүүлгийн код нь олон нийтийн, хувийн өргөн нэвтрүүлгийн аль алинд нь шаардлага тавьдаг (жишээ нь, хувийн өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрлийг хадгалах нөхцөл болдог)

сонгуулийн үеэр нэр дэвшигчдэд эфирийн цаг хуваарилах, олон нийтийн санал асуулгыг мэдээлэх, улс төрийн зар сурталчилгааны хувь хэмжээ, улс төрийн намын сонгуулийн дамжуулалт, дотоодын сонгуулийн хуулинд заагдсаны дагуу эрх мэдэлтнүүдэд эфирийн илүү цаг хуваарилахаас зайлсхийх зэрэг шударга, тэнцвэртэй, тал тохой татахгүй байх зарчмыг баталгаажуулсан зохицуулалттай

тус код нь урьдчилсан цензур тавих гэх мэт асуудлаар хэвлэл мэдээллийн редакцийн хараат бус байдалтай зөвшилцдөггүй

олон улсын стандартад нийцдэг

Нотлох аргууд

- өргөн нэвтрүүлгийн шударга байх, тал тохой татахгүй байхтай холбоотой агуулгыг зохицуулсан аливаа хууль тогтоомж
- өргөн нэвтрүүлгийн кодын үр дүнтэй байдлын талаар итгэл даахуйц байгууллагын тайлан
- сонгуулийн үеэр мэдээ, сурвалжлага бэлдэхтэй холбоотой аливаа зохицуулалт
- өргөн нэвтрүүлэгчид парламентын үйл ажиллагааны талаар шударга, тэнцвэртэй сурвалжлага дамжуулдаг тухай мэдээлэл

3.10 ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН КОДЫГ ҮР ДҮНТЭЙГЭЭР ДАГАЖ МӨРДДӨГ

тус кодыг зөрчсөн тохиолдолд тохирох хариуцлага хүлээлгэдэг

олон нийтийн санал гомдолд үйлчлэх зохистой тогтолцоотой

зохицуулалтыг редакцийн эрх чөлөө, хараат бус байдлыг харгалзан дагаж мөрддөг

Нотлох аргууд

- хараат бус зохицуулагч байгууллага өргөн нэвтрүүлгийн код хэрэгжүүлэхийг дэмжсэн тохиолдол

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19 – country-specific analyses of media laws relating to fairness and impartiality:

www.article19.org

Article 19, Guidelines for Election Broadcasting in Transitional Democracies:

www.article19.org/pdfs/tools/electionbroadcastingtrans.pdf

Article 19, *Broadcasting Pluralism and Diversity: Training Manual for African Regulators*,

2006: www.article19.org/pdfs/tools/broadcasting-manual.pdf

Commonwealth Broadcasting Association and UNESCO, *Guidelines for Broadcasting Regulation*:

http://portal.unesco.org/ci/en/files/21345/11399384219Guidelines_for_Broadcasting_Regulation.pdf
Guidelines+for+Broadcasting+Regulation.pdf
Recommendation CM/Rec (2007) 15 of the Council of Europe on measures concerning media coverage of election campaigns
USAID, Office of Democracy and Governance, *The Enabling Environment for Free and Independent Media: Contribution to Transparent and Accountable Governance*, 2002:
www.usaid.gov/our_work/democracy_and_governance/publications/pdfs/pnacm006.pdf

Е. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ОЛОН НИЙТИЙН ИТГЭДЭГ ЭСЭХ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Нийгэм, хэвлэл мэдээлэлд хэр итгэл, найдвар хүлээлгэдгийг хэмжихэд бэрх. Үнэлэх үнэлэмж нь ихэнхдээ субъектив бөгөөд бүрэн бус өгөгдлөөс хамааралтай. Түүнчлэн санал асуулгаар ихэвчлэн эрх мэдэл бүхий олны танил хүмүүс эсвэл итгэл үнэмшлийн талаар хэвлэл мэдээллээр хэлэлцэх үед түүнд итгэх итгэл суларсан нь харагддаг.

Хүйн хэвлэл мэдээлэл олон нийтийн итгэл найдварыг хэмжих онцгой боломж агуулдаг. Хүйн өргөн нэвтрүүлэгчдийг үнэлэх, тэдний мандатыг үргэлжлүүлэхэд нутгийн ард иргэд оролцдог байх жишээтэй.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд нөөц бололцоогоо харгалзан өөрсдийн үзэгч, сонсогч, уншигчдын дунд судалгаа явуулж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллахыг чармайх хэрэгтэй. Чухамдаа, хэвлэл мэдээлэл өөрөө сэтгүүл зүйд итгэх олон нийтийн итгэлийн тухай хэлэлцүүлэг явуулах гол хэрэгсэл мөн.

Блог хөтлөх соёл, иргэний сэтгүүл зүйн хөгжил нь олон нийт болон хэвлэл мэдээллийн харилцааг үндсээр нь өөрчилсөн. Олон улс орны ард иргэд мэдээллийн идэвхгүй хүлээн авагчид бус харин хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, агуулга боловсруулах, хувийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс хэрэглээг зохицуулж, мэргэжлийн сэтгүүлчдийн үйл ажиллагаанд санал дүгнэлт өгдөг.

Гэсэн хэдий ч, интернет хүртэх боломж хязгаарлагдмал иргэд энэ чиглэлээс өөрсдийгөө орхигдсон хэмээн үзэж болно. Тиймээс, хэвлэл мэдээллийн байгууллагууд уг салбарын хэрэгцээ шаардлагыг үл тоомсорлож болохгүй. Үүний адил, мэдээллээр хамгийн их гачигдан, өөрсдийн санаа бодлыг бусдад хүргэх хамгийн бага боломж бүхий эмэгтэйчүүд, нийгмээс тусгаарлагдсан давхаргын итгэлийн хэм хэмжээнд боломжийн хэрээр үнэлгээ хийх шаардлагатай

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.11 ОЛОН НИЙТ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ӨНДӨР ИТГЭЛД НАЙДВАР ХҮЛЭЭЛГЭДЭГ

хэвлэл мэдээлэл нь нийгмийн санаа зовоож буй асуудлыг хөнддөг гэсэн хандлагатай орон нутгийн, үндэсний мэдээ, мэдээллийн тэнцвэртэй байдалд сэтгэл хангалуун байдаг сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагууд нь шударга бөгөөд авилгад автаагүй гэсэн хандлагатай

дамжуулж буй мэдээ нь шударга, тал тохой татаагүй гэсэн хандлагатай

хэвлэл мэдээлэл дэх иргэдийн өргөн оролцоог үзэгч, сонсогчид ярилцлага нэвтрүүлэгт оролцсон хэмжээ, сонин хэвлэлд уншигчдын санал бодлын булан гаргах зэргээр хэмжигддэг

Нотлох аргууд

- хэвлэл мэдээлэлд итгэл найдвар хүлээлгэхтэй холбоотой олон нийтийн санал асуулга
- радио сонсогчдын клуб ажиллуулах зэргээр хэвлэл мэдээлэлд үнэлгээ хийх
- хэвлэл мэдээллийн асуудалд холбогдох өрхийн судалгаа явуулах болон бусад үйл ажиллагаа
- сонсогч, үзэгч, уншигчдын дунд тэдний хэвлэл мэдээлэлд хандах хандлагын талаар ярилцлага хийх
- хүйн өргөн нэвтрүүлэгчдийн үнэлгээнд хүй олныг оролцуулсан баримт

3.12 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД ӨӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГАД ХАРИУ ҮЗҮҮЛДЭГ

хэвлэл мэдээллийн байгууллагууд нь өөрсдийн үзэгч сонсогч уншигчдын талаар, өөрийн мэдээ, нэвтрүүлгийн чанар, соёлын олон талт байдалд хандах хандлагын талаар илүү мэдээлэлтэй байх оролдлого хийдэг

хэвлэл мэдээллийн байгууллагууд нь утсан холбоо, хэлэлцүүлэг, иргэдийн мэдээлэл зэрэг үзэгч сонсогчдын оролцооны суваг гаргадаг

хэвлэл мэдээллийн байгууллагууд нь ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулах дотоод аудитын бүтэцтэй

хүйн хэвлэл мэдээллийг үнэлэх хүй олонд тулгуурласан бүтэцтэй

Нотлох аргууд

- хэвлэл мэдээллийн байгууллагууд үзэгч, сонсогч, уншигчдын талаар судалгаа хийдэг тухай баримт
- хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтийн шүүмжлэл буюу тэдний зүгээс итгэл үзүүлэхгүй байгаад хариу үйлдэл үзүүлдэг тухай баримт
- хэвлэл мэдээллийн байгууллагууд нь үзэгч, сонсогчдын оролцооны суваг ажиллуулдаг тухай баримт
- омбудсмен, хэрэглэгчдийн холбоо зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын гаргасан баримт

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

BBC World Service Trust – research and learning:

<http://www.bbc.co.uk/worldservice/trust/researchlearning/AnnualEdelmanAnnualTrust>

Barometer 2006: www.edelman.co.uk/insights/trust/Edelman%20Trust%20Barometer%202006.pdf

Globescan 2006, BBC/Reuters/Media Center Poll: Trust in the Media:

www.globescan.com/news_archives/bbcrcrout.html

International Institute for Democracy and Electoral Assistance – works with organisations worldwide to support the compilation of four major regional democracy barometers. Links to all four barometers at: www.idea.int/democracy/global-barometers.cfm

MediaWise – project on public trust in the media:

www.mediawise.org.uk/display_page.php?id=72

Pew Global Attitudes Project – a series of worldwide public opinion surveys: <http://pewglobal.org/>

Pew Global Attitudes Project: Truly a World Wide Web – Globe Going Digital:

<http://pewglobal.org/reports/display.php?ReportID=251>

Telecom Express 2006, Television is as Trustworthy as Friends: Survey:

www.precipitations.com/telecomexpress/fullarticle.php?id=41

Transparency International – Corruption Perceptions Index:

www.transparency.org/policy_research/surveys_indices/global/cpi

F. СЭТГҮҮЛЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Үзэл бодлын эрх чөлөөний баталгаажилт нь сэтгүүлч эл эрхээ аюулгүй орчинд эдэлж чадахгүй тохиолдолд үнэ цэнээ алддаг. Сэтгүүлч эсвэл хэвлэл мэдээллийн байгууллага нь мөрдлөг, заналхийлэл буюу бие эрхтэний халдлагад өртөх аваас хэвлэл мэдээлэл ардчилсан яриа хэлэлцүүлэг өрнүүлэх талбар болох өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй. Сайн дурын болон цагийн ажилтнууд хэвлэл мэдээллийн салбарын хамгийн эмзэг гишүүд нь байдаг. Ажиллах нөхцөл тааруу, авлигад автах зэрэг нь өөрийн цензурт хөтөлдөг.

Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийг эрх барих эсвэл хуулиас гадуур хүчнүүдийн аль аль нь үйлддэг. Ямар ч тохиолдолд, ял шийтгэлгүй өнгөрөөх нөхцөл бүрэлдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дээрх гэмт хэргийг хуулийн дагуу мөрдөн шалгадаг байх нь чухал. Түүнчлэн, сэтгүүлчийн нууц эх сурвалжийн нууцыг албадан илчлэхээс хамгаалах шаардлагатай. Эх сурвалжийн нууц нь мэргэжлийн сэтгүүл зүйн үндэс суурь бөгөөд олон улсын хуулиар хамгаалагдсан байдаг.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.13 СЭТГҮҮЛЧИД, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД АЮУЛГҮЙ ОРЧИНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЯВУУЛДАГ

сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд сүрдүүлэг заналхийлэл, мөрдлөг хавчлагад өртдөггүй

хуулинд нийцэх мэргэжлийн үүргээ гүйцэтгэсний улмаас сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын бие эрхтэнд халдах, хууль бусаар баривчлах, амь насанд нь халдах тохиолдол гардаггүй

хуулинд нийцэх мэргэжлийн үүргээ гүйцэтгэсний улмаас хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох буюу зогсоохоор сүрдүүлдэггүй сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдсэн гэм хэргийг мөрдөн шалгадаг, үл шийтгэх явдал гардаггүй

хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалдаг

нийгмийн хамгааллын арга хэмжээ нь цагийн, сайн дурын зэрэг бүх ажилтанд хүртээмжтэй байдаг

Нотлох аргууд

- сүрдүүлэг заналхийлэл, бие эрхтэн, амь насанд нь халдсан, хууль бусаар баривчилсан тохиолдлуудын тоо баримт
- хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосон, зогсоохоор сүрдүүлсэн тохиолдлууд
- сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдсэн гэм хэргийг мөрдөн шалгаж, хэрэгт татсан, буюу мөрдөн шалгаж, ял шийтгэл ногдуулаагүй тухай баримт

3.14 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА АЮУЛТАЙ ОРЧНООС ҮҮДЭН ХОХИРОЛ АМСДАГГҮЙ

сэтгүүлчид ял шийтгэл, сүрдүүлэг заналхийлэл, халдлагаас айсны улмаас өөрийн цензурт автахгүй байх

эх сурвалжийн нууцыг хуулиар хамгаалж, бодит амьдрал дээр дээдэлдэг

Нотлох аргууд

- сэтгүүлчид, олон нийтийн дунд хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлын талаар хэлэлцүүлэг хийсэн тохиолдлууд
- сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын удирдлагын дунд хөдөлмөрлөх орчных нь талаар хийсэн судалгаа
- сэтгүүлчдийн өөрийн цензурын хэмжээг илрүүлэх талаар хийсэн итгэл даахуйц байгууллагын агуулгын дүн шинжилгээ
- сэтгүүлчдийн эх сурвалжаа илчлэх дарамтанд өртсөн тохиолдлууд

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

UNESCO Medellin Report “Press Freedom: Safety of Journalists and Impunity”, 2007:

<http://unesdoc.unesco.org/images/0015/001567/156773e.pdf>

Committee to Protect Journalists: Journalists Killed Statistics:

www.cpj.org/killed/killed_archives/stats.html

Freedom House – *Freedom of the press survey* – indicators relating to political environment: www.freedomhouse.org/uploads/PFS/PFSMethodology2006.pdf

www.freedomhouse.org/uploads/PFS/PFSGlobalTables2006.pdf

International Federation of Journalists – annual reports on journalists and media staff killed:

www.ifj.org/default.asp?Issue=KILL&Language=EN

International Freedom of Expression exchange – information on safety of journalists:

www.ifex.org/en/content/view/full/240/

International Freedom of Expression exchange – information on impunity:

www.ifex.org/en/content/view/full/237/

International News Safety Institute: www.newssafety.com

International Research and Exchanges Board – *Media Sustainability Index*:

www.irex.org/msi/index.asp

Reporters sans Frontières – *Worldwide Press Freedom Index*:

www.rsf.org/rubrique.php3?id_rubrique=554

Ангилал 4. Мэргэжлийн чадавхи эзэмшүүлэх ба илэрхийлэх эрх чөлөө, олон ургальч, олон талт байдлыг хөхиүлэн дэмжихэд тусламж үзүүлдэг байгууллагууд

А. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ БИЙ ЭСЭХ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хэвлэл мэдээллийн салбар дахь сургалтаар тусгай курс, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрөөс эхлээд ажлын байран дахь сургалт, дадлагын ажил, зайны сургалт хүртэл өргөн хүрээний үйл ажиллагааг хамруулна. Сургалтыг ажил олгогч, хэвлэл мэдээллийн сургалт эрхэлдэг боловсролын байгууллага, их дээд сургуулийн тэнхим, мэргэжлийн эвлэл холбоод буюу хэвлэл мэдээллийг дэмжих, түүний хөгжилд хувь нэмэр оруулагч олон улсын байгууллагууд явуулж болно.

Зарим оронд сэтгүүлчид ажиллах явцдаа сургалтад хамрагдаж, дэмжлэг авах бололцоо бүхий хэвлэл мэдээллийн мэргэжлийн сургалтын төвүүд үйл ажиллагаа явуулдаг. Ажил олгогч болон академик байгууллыг нэгтгэсэн салбар дундын сургалтын зөвлөл мөн сайн туршлага нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж болно.

Сэтгүүл зүйн сургалтын ерөнхий, мэргэжлийн онцлог нь бүх нийтийн байхын зэрэгцээ тухайн

нутаг дэвсгэрийн мэдээллийн хэрэгцээнд тулгуурласан, аль болох орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад хамтран зүтгэгчдийн оролцоотойгоор, өөрөөр хэлбэл нутгийн ард иргэдийн боловсруулж, тэдэнд зориулсан мэдээллээр хөтлүүлсэн сургалт илүү үр нөлөөтэй байдаг. Сургалтын хөтөлбөрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн зах зээлд тохируулж боловсруулах нь нэн чухал. Сургалтын хүрээ нь онолын үүднээс сэтгүүл зүй, бүтээмж, удирдлагын асуудлыг хамрахаас гадна хэвлэл мэдээллийн хууль, бодлого, зохицуулалт, мөн хэрхэн үр ашигтай үйл ажиллагаа явуулах тухай тусгах нь чухал. Түүнчлэн, орон нутгийн нөлөөллийн бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч хэвлэл мэдээллийн ажилтнуудыг нийгмээс тусгаарлагдсан давхаргын төлөв байдлын талаар мэдээлэх боломж олгоно. Хэвлэл мэдээллийг хянаж, нухчин дарангуйлдаг улс оронд сэтгүүл зүйн ёс зүй, эрэн сурвалжлага хийх, сонгуулийн сурвалжлага, мэдээ бэлдэх арга техникийн талаар мэдлэг түгээх нь нэн хэцүү.

Сургалтын үйл ажиллагаа тогтвортой бөгөөд урт хугацааны байх нь чухал, хэвлэл мэдээлэлд үзүүлэх гадны тусламж нь мэдээ, зар сурталчилгааны зохиомлоор хөөрөгдсөн зах зээл бий болгох аюул дагуулдаг буюу үүсгэн байгуулагч нь тусламж авангуут алга болдог хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүсэх нөхцөл бүрдүүлдэг. Сургалт явуулж буй байгууллагууд, ялангуяа зорилтот улс орны хувьд гадны болох байгууллагууд давтагдагдахаас сэригййлэхийн тулд үйл ажиллагаагаа зөв чиглүүлэх шаардлагатай.

ЮНЕСКО нь иж бүрэн, нэгдмэл хандлагад үндэслэн сэтгүүл зүйн боловсролын загвар хөтөлбөрийг (өгөгдлийн эх сурвалж үзнэ үү) боловсруулсан юм. ЮНЕСКО сэтгүүлчдэд боломж бүрдүүлэхийн ач холбогдлыг онцолдог, ялангуяа ажил мэргэжлийн оргил үеийн сэтгүүлчид, мэргэжлийн хувьд сонирхол татахуйц асуудлаар мэдлэг олгох, түүнчлэн техникийн болоод мэргэжлийн ур чадвар дээшлүүлдэг.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦСЭН СУРГАЛТАД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ

- сэтгүүлчдийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөртэй
- дотоод гадаадын давтамж хуваарилагчаас гаргасан сургалтын хөтөлбөртэй
- бүх түвшний мэргэшсэн сэтгүүлчдийн ур чадвар, зан байдлын талаарх мэдлэг дээшлүүлэх боломжтой
- бүс нутаг, олон улсын солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой
- тусгай сэдвийн хүрээнд мэргэших шаардлага бүхий сэтгүүлчдийг дэмждэг
- мэдээллийн технологийн ур чадвар дээшлүүлэх сургалттай
- сэтгүүлчид зайн сургалтад хамрагдах боломжтой
- сэтгүүлчдэд зориулсан сургалт дан ганц хот суурин газар төвлөрөх бус, биечлэн хамруулдаг
- сургалтын агуулга нь онол практик хослуулдаг
- сургалт тухайн орны хэл дээр явагддаг ба тохиромжтой технологи ашигладаг

- сургалтын материал нь нутгийн хэл дээр бэлтгэгддэг
- эмэгтэйчүүд, нийгмээс тусгаарлагдсан давхарга сургалтад хамрагдах боломжтой
- сургалтын хөтөлбөрийг оролцогчдоор үнэлүүлдэг
- сургалтаар удирдлагын сайн тогтолцоо, ил тод байдал, удирдлага ба ажилтнуудын хоорондын харилцан ярианы хэрэгцээ шаардлагын тухай ойлголт олгодог

Нотлох аргууд

- мэргэжлийн боловсролын байгууллагаар сургагдсан сэтгүүлчдийн тоо
- мэргэжлийн эвлэл холбоо, хөндлөнгийн ТББ-ууд зэрэг бусад сувгаар сургалтад хамрагдсан сэтгүүлчдийн тоо
- сэтгүүлчдийн дунд явуулсан судалгаагаар сургалтын үр дүнд сэтгэл хангалуун оролцогчдын хувь хэмжээ, ёс зүйн хэм хэмжээний тухай тэдний ойлголтыг хэмжсэн хэмжүүр
- сэтгүүлчдэд зориулсан сургалтын хүртээмж, чанарын тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- сэтгүүл зүйн сургалтын стратеги, хөтөлбөр
- хэвлэл мэдээллийн байгууллагуудын бодлого, хүний нөөцийн хөгжлийн талаар баримтлах дотоод үйл ажиллагаа
- салбар хоорондын сургалтын зөвлөл, ажил олгогчдын нэгдсэн сургалт, сургалтын байгууллага буй эсэх
- сургагч багш нараар сургалтын үнэлгээ хийлгэдэг

4.2 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАДАА НИЙЦСЭН СУРГАЛТАД ХАМРАГДДАГ

- хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагуудад зориулсан сургалттай
- маркетинг, санхүүгийн меменжмент зэрэг бизнесийн ур чадвар дээшлүүлэх сургалттай
- эмэгтэйчүүд, нийгмээс тусгаарлагдсан давхаргад хүртээмжтэй сургалтын хөтөлбөртэй

Нотлох аргууд

- албан ёсны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт хамрагдсан удирдах албан тушаалтан, санхүүгийн ажилтнуудын тоо
- мэргэжлийн эвлэл холбоо, хөндлөнгийн ТББ-ууд зэрэг бусад сувгаар дамжуулан сургалтад хамрагдсан удирдах албан тушаалтан, санхүүгийн ажилтнуудын тоо
- удирдах албан тушаалтан, санхүүгийн ажилтнуудын дунд явуулсан судалгаагаар сургалтын үр дүнд сэтгэл хангалуун оролцогчдын хувь хэмжээ, ёс зүйн хэм хэмжээний тухай тэдний ойлголтыг хэмжсэн хэмжүүр

4.3 СУРГАЛТААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУДАД АРДЧИЛАЛ, ХӨГЖЛИЙН ТАЛААР МЭДЛЭГ ОЛГОДОГ

- сургалтаар ардчилал, хүний эрхийг дэмжих хэвлэл мэдээллийн боломж, чадварын тухай ойлголт мэдлэг олгодог
- сургалт нь сэтгүүлчдэд нийгмээс тусгаарлагдсан давхаргын төлөв байдлын талаар мэдээлэх чадвар олгодог
- сургалт нь сэтгүүлчдэд эрэн сурвалжлагын ур чадвар, түүнтэй холбоотой зан төлвийн талаар мэдлэг олгодог
- сургалт нь сэтгүүл зүйн ёс зүй, эрсдэлийн тухай ойлголт, анхны тусламжийн талаар мэдлэг олгодог

Нотлох аргууд

- сэтгүүлчдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн агуулга
- сургалтыг сургагч багш нараар үнэлүүлэх
- хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан ардчилал, хүний эрхийн зорилгуудтай холбоотой сургалтын үр дүнгийн тухай итгэл даахуйц байгууллагын тайлан
- ёс зүй, хүний эрх, нийгмээс тусгаарлагдсан давхаргын төлөв байдлын тухай сэтгүүлчдийн ойлголтыг хэмжсэн хэмжүүр
- сэтгүүл зүйн сургуулийн төгсөгчдөд төрөл бүрийн салбараар мэргэших сургалт явуулсны ач холбогдол, үр дүнд хийсэн судалгаа (жишээ нь: ХДХВ-ын тухай мэдээлэх)

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

BBC World Service Trust: www.bbc.co.uk/worldservice/trust/mediadevelopment Commonwealth Press Union: www.cpu.org.uk/tr_courses.html

Communication for Social Change Consortium: www.communicationforsocialchange.org European Federation of Journalists Questionnaire on Quality in Journalism: www.ifj-europe.org/default.asp?index=4347&Language=EN

Global Forum for Media Development: http://70.87.64.34/~intint/gfmd_info/index.php

Global Media Monitoring Project – advocacy training workshops on gender: www.whomakesthenews.org/events/workshops

Institute of War and Peace Reporting: www.iwpr.net/index.php?apc_state=heno-top_programmes_new.html&s=o&o=training_index1.html

International Federation of Journalists, *IFJ research findings on reporting HIV/AIDS in six countries in Africa and Asia*: www.ifj.org/pdfs/IFJ%20HIV%20RESEARCH%20REPORT.pdf

International Federation of Journalists ReportStage-e virtual training centre for journalists: www.ifj.org/default.asp?Issue=RStage&Language=EN

International Federation of Journalists – Europe-India gender project: www.ifj.org/default.asp?Issue=Gender%20india&Language=EN

International Journalists' Network – international directory of media assistance initiatives: www.ijnnet.org/Director.aspx?P=MediaAssistance

International News Safety Institute: www.newssafety.com

Internews: www.internews.org/activity/training/default.shtm

Media Institute of South Africa: www.whomakesthenews.org/events/workshops MediaWise – directory of journalism training and degree courses worldwide: www.presswise.org.uk/display_page.php?id=41
Panos Institute: www.panos.org
Reuters foundation: www.foundation.reuters.com
Southern Africa Media Training Trust: www.nsjtraining.org
Thomson foundation: www.thomsonfoundation.co.uk UK Broadcast Journalism Training Council: www.bjtc.org.uk/about.aspx UK National Council for the Training of Journalists: www.nctj.com
UNESCO, *Criteria and indicators for quality journalism training institutions & identifying potential centres of excellence in journalism training in Africa*, 2007: <http://unesdoc.unesco.org/images/0015/001514/151496E.pdf> UNESCO, *Model Curricula for Journalism Education for Developing Countries and Emerging Democracies*, 2007: <http://unesdoc.unesco.org/images/0015/001512/151209E.pdf>
UNESCO – media development activities: http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=4625&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html Union Network International <http://www.union-network.org>
World Association of Newspapers: www.wan-press.org/article37.html
Specific media organisations: documentation relating to training strategy, human resource development, editorial guidelines, training curricula etc.

В. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АКАДЕМИК БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ ЭСЭХ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Сэтгүүл зүйн академик курс, хэвлэл мэдээлэлд хамаарах үйл ажиллагааны бусад талууд нь практик ур чадвар, мөн хэвлэл мэдээллийн бодлогын талаарх шүүмжлэлтэй хандлага, хэвлэл мэдээллийн нийгэмд гүйцэтгэх үүргийг дэмжих арга хэрэгсэл болдог. Академик сургалтын төв олон нийтийн хэвлэл мэдээллийн талаарх хэлэлцүүлэг болж, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай сургалтын хөтөлбөр боловсруулах, сайн туршлага нэвтрүүлэх үйл явцад хамтардаг. (жишээлбэл, салбар хоорондын сургалтын зөвлөлөөр дамжуулах)

Академик курсууд хэвлэл мэдээллийн ажилтнуудыг мэргэжлийн сэтгүүл зүйн салшгүй чухал шинж чанар болох хараат бус санаа бодолтой байх, дүн шинжилгээ хийхэд шаардагдах ур чадвар олгохын зэрэгцээ мэдээ сурвалжлага бэлдэх салбарын талаар шаардлагатай мэдлэг олгох ёстой.

Курсууд нь боломжтой, хүртээмжтэй байх ба зөвхөн арилжааны үйлчилгээ үзүүлэгчдийн ашиг сонирхлын бүс болоод зогсохгүй төсвийн хөрөнгөөр давуу эрх олгогдох ёстой. Сургалтын хөтөлбөрийг тогтмол хугацаанд эргэн хардаг байх нь зүйтэй. Орчин үеийн харилцаа холбооны асар хурдацтай хөгжлийн эрин үед үйл явдлын өрнөл түргэн хуучирч, хэвлэл мэдээллийн салбарын хэрэгцээнд нийцэхээ больдог.

Академик сургалтын чухал бүрэлдэхүүн хэсэг бол хэвлэл мэдээллийн тухай ойлголт мэдлэг олгох

явдал юм. Харилцаа холбооны хөгжилд блог хөтлөх, гар утас, хэвлэл мэдээлэл болон иргэдийн хоорондын хоёр талт харилцааны бусад хэлбэрүүдийг ашиглах явдал ихсэхтэй зэрэгцэн харилцаа холбооны “бизнесийн загвар” бий болгоход иргэдийн харилцан үйлдэл маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.4 АКАДЕМИК БОЛОВСРОЛ НЬ ӨРГӨН ХҮРЭЭНИЙ ОЮУТНУУДАД ХҮРТЭЭМЖТЭЙ

- их, дээд сургууль, коллежийн төгсөх ангийн оюутан, магистрантууд сэтгүүл зүйн курст хамрагдах боломжтой**
- сургалтын материал, сурах бичиг нутгийн хэл дээр бэлтгэгддэг**
- хэвлэл мэдээллийн сургалт явуулдаг байгууллагууд техник, шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээлэл, харилцаа, технологийн хүртээмжтэй**

Нотлох аргууд

- үйл ажиллагаа явуулж буй сэтгүүл зүйн курсуудын тоо
- улсын болон хувийн боловсролын байгууллагуудын харьцаа
- салбар хоорондын сургалтын зөвлөл бий эсэх
- академик боловсрол олгох байгууллага тухайн салбарын ажил олгогчдын хоорондын идэвхтэй холбоо

4.5 АКАДЕМИК КУРС СУРАЛЦАГСДАД АРДЧИЛЛЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР МЭДЛЭГ, УР ЧАДВАР, МЭДЛЭГ ОЛГОДОГ

- уг курсээр хэвлэл мэдээллийн хууль, ёс зүй, зохицуулалт, төрийн бодлогын талаар мэдлэг олгодог**
- хэвлэл мэдээллийн ардчилал, хүний эрхийг дэмжих чадварын талаар ойлголт өгдөг**
- курс нь суралцагчдад хараат бус санаа бодол, дүн шинжилгээ хийх чадвар олгодог**
- сэтгүүлчдийн сурвалжлага хийх салбарт зайлшгүй баримтлах сахилга, зан төлвийн тухай мэдлэг олгодог**
- курсээр орчин үеийн харилцаа холбооны орчинд нийцэхүйц хэвлэл мэдээллийн талаар мэдлэг олгодог**

Нотлох аргууд

- курсийн сургалтын хөтөлбөрт итгэл даахуйц байгууллагын хийсэн үнэлгээ
- академик боловсрол олгох байгууллагууд хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, судалгаа шинжилгээний байгууллагуудтай сургалтын хөтөлбөр боловсруулахад хамтарч ажилладаг, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулдаг тухай

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Global Network for Professional Education and Training in Media: http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=13496&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html

International Journalists' Network: www.ijnet.org

UK Broadcast Journalism Training Council: www.bjtc.org.uk/about.aspx

UNESCO, *Communication Training in Africa: Model Curricula, Non-degree and Degree programmes* – offers model curricula to train and prepare communication practitioners:

www.unesco.org/webworld/publications/com_training_en.pdf

UNESCO, *Criteria and indicators for quality journalism training institutions & identifying potential centres of excellence in journalism training in Africa*, 2007:

<http://unesdoc.unesco.org/images/0015/001514/151496E.pdf>

С. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД БУЙ ЭСЭХ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хэвлэл мэдээллийн ажилтнууд олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан үйлдвэрчний эвлэл байгуулах эрхээ айх айдасгүй, ял шийтгэлгүйгээр эдлэх ёстой.

Үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн эвлэл холбоод шударга бусаар ажлаас халах, цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, эх сурвалж хамгаалах, үгээ чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой мэргэжлийн эрх ашгийг хамгаалахад шууд нөлөөлөл үзүүлэх чадвартай. Мөн сургалт явуулах, ёс зүйн код нэвтрүүлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэргэжлийн хэм хэмжээг дээшлүүлдэг.

Хэвлэл мэдээллийн ажилтнууд бусад салбарынхантай харьцуулахад хангалттай нөхөн олговор, урамшуулал авдаг байх нь чухал.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.6 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД ХАРААТ БУС ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛД НЭГДЭХ ЭРХ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

- эвлэл холбоо байгуулах эрхийг хуулиар баталгаажуулж, амьдрал дээр хэрэгжүүлдэг
- хамт олноороо эсэргүүцэл илэрхийлэх үйлдлийг хуулиар баталгаажуулж, амьдрал дээр хэрэгжүүлдэг
- үндэсний сэтгүүлчдийн эвлэл нь олон улсын мэргэжлийн эвлэл холбоонд гишүүнээр элсэх эрхээ эдэлдэг

Нотлох аргууд

— үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсвэл мэргэжлийн эвлэл холбооны гишүүн сэтгүүлчдийн хувь

ХЭМЖЭЭ

- олон улсын үйлдвэрчний эвлэл, мэргэжилтнүүдийн салбар, ажил олгогчдын байгууллага
- хамт олноороо эсэргүүцэл илэрхийлсэн тохиолдлууд
- хараат бус үйлдвэрчний эвлэлийн гишүүн болохын хувьд шийтгэл амссан буюу мөрдөгдсөн сэтгүүлчдийн тухай баримт

4.7 ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛ, МЭРГЭЖЛИЙН ЭВЛЭЛ ХОЛБООД МЭРГЭЖЛИЙН ЭРХ АШИГ ХАМГААЛДАГ

- үйлдвэрчний эвлэл нь хөдөлмөр, мэргэжлийн асуудлаар ажил олгогчидтой яриа хэлэлцээ хийх түнш хэмээн тооцогддог
- мэргэжилтнүүдийн холбоо, хэвлэлийн клуб зэрэг мэргэжлийн сэтгүүл зүйн эвлэл холбоод нь хэвлэлийн ёс зүй, стандартын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлдэг
- ажил олгогчдын холбоо хэм хэмжээ тогтоож, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тууштай хамгаалдаг
- үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн эвлэл холбоод ёс зүйн кодыг түгээн дэлгэрүүлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тууштай хамгаалдаг
- үйлдвэрчний эвлэл хэвлэл мэдээллийн эмэгтэй ажилтнуудын эрх ашгийг хамгаалдаг

Нотлох аргууд

- сэтгүүл зүйн эвлэл холбоод мэргэжлийн эрх ашиг хамгаалдаг тухай баримт
- үйлдвэрчний эвлэлийн байгууллага нь хэвлэл мэдээллийн бодлого, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулдаг тухай баримт

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Association for Independent Broadcasting: www.aib.org.uk/index.asp?node_id=8,95 Communication

for Social Change Consortium: www.communicationforsocialchange.org

International Federation of Journalists – list of members: www.ifj.org/pdfs/MembersList2006.pdf

International Journalists' Network: www.ijnet.org

Union Network International: www.union-network.org

World Association of Newspapers: www.wan-press.org World Editors' Forum: www.wan-press.org/wef/articles.php?id=2

D. ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ОРОЛЦДОГ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) хэвлэл мэдээлэлд дэмжлэг үзүүлж, хараа хяналт тавьдаг, эрүүл саруул орчных нь чухал хэсэг мөн. ИНБ нь хэвлэл мэдээллийн агуулга, өмчлөлд хяналт шинжилгээ хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүл зүйн аюулгүй байдал, хэвлэл

мэдээллийн бодлого, зохицуулалтын асуудалд шууд нөлөөлөл үзүүлэх, чадавхи бий болгох, ард иргэдийн мэдээлэл авах, дуу хоолойгоо хүргэхэд туслах зэрэг үйлст чухал үүрэг гүйцэтгэдэг.

ИНБ8 хэвлэл мэдээллийн хэрэгслийг нийгмийн бүх салбарын мэдээллийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх талаар хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчидтай хамтран ажилладаг. Мөн өөрсдийн туршлага, ард иргэдтэй байгуулсан холбоогоор дамжуулж, ХДХВ гэх мэт асуудлын талаар мэдээлэх бололцоотой бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэг талыг барьсан мэдээлэл дамжуулахгүй байх, нийгмээс тусгаарлагдсан давхаргын дуу хоолойг хүргэхээс зайлсхийхгүй байх тал дээр анхаарч чадвартай. Иргэний сэтгүүл зүй болон хэрэглэгчээр удирдуулсан агуулга бий болсон нь ИНБ-ийн нөлөөлөл, түүний хэвлэл мэдээлэлтэй холбогдох шинэ арга зам бий болгосон.

ИНБ нь сайн туршлагыг нэвтрүүлэн түгээхэд түлхэц болох хэвлэл мэдээллийн талаарх шүүмжлэлт, хараат бус бодол санааны эх сурвалж нь болдог.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.8 ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД СИСТЕМТЭЙГЭЭР ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙДЭГ

- иргэний нийгмийн байгууллагууд хэвлэл мэдээллийн агуулга, өмчлөлд олон ургальч, олон талт байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор хяналт шинжилгээ хийдэг
- иргэний нийгмийн байгууллагууд нэн ялангуяа нийгмээс тусгаарлагдсан давхаргын төлөөний өмнөөс хэвлэл мэдээлэлд шүүмжлэл бүхий дүн шинжилгээ хийдэг,
- иргэний нийгмийн байгууллагууд хэвлэл мэдээллийн тухай ойлголт мэдлэг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг

Нотлох аргууд

- хэвлэл мэдээллийн хяналт шинжилгээний үр дүнд гарсан иргэний нийгмийн байгууллагуудын судалгаа
- иргэний нийгмийн байгууллагуудын лобби, нөлөөллийн үйл ажиллагаа
- эргэх холбоог хангаж, үнэлгээ хийдэг радио сонсогчдын клуб г.м. үйл ажиллагаа явуулдаг

4.9 ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ АСУУДЛААР НӨЛӨӨЛЛИЙН ШУУД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ

- иргэний нийгмийн байгууллагууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэлтэй байх эрх, сэтгүүлдчийн аюулгүй байдлыг тууштай дэмждэг
- иргэний нийгмийн байгууллагууд, төрөөс хэвлэл мэдээллийн талаар хэрэгжүүлэх бодлогын асуудлаар бодлого боловсруулагчидтай хамтран ажилладаг

Нотлох аргууд

- иргэний нийгмийн байгууллагууд мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжигч олон улсын иргэний нийгмийн сүлжээнд хамрагддаг
- иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бодлого боловсруулагчид хамтран хэвлэл мэдээллийн бодлогын асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх олон нийтийн арга хэмжээ зохион байгуулдаг

4.10 ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ХҮЙ ОЛНЫ МЭДЭЭЛЭЛ АВАХ, ДУУ ХООЛОЙГОО ХҮРГЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛДЭГ

- **иргэний нийгмийн байгууллагууд хэвлэл мэдээллийг хүртэх гэсэн эрмэлзэлтэй хүмүүст зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлдэг**
- **иргэний нийгмийн байгууллагууд сэтгүүлчдэд зориулсан сургалт явуулж, чадавхи бий болгодог**

Нотлох аргууд

- хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд хамтарч нөлөөллийн хөтөлбөр, хэвлэл мэдээллийн талаарх ойлголт, мэдлэг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг тухай баримт
- иргэний нийгмийн байгууллагууд хэвлэл мэдээллийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Article 19 – directory of partner organisations worldwide: www.article19.org/work/regions/index.html

Civicus – Worldwide Alliance for Citizen Participation; produces a qualitative civil society index across 35 countries: www.civicus.org

The Communication Initiative: www.comminit.com

Communication for Social Change Consortium: www.communicationforsocialchange.org

Cyberjournalist.net: www.cyberjournalist.net

Independent Media Center – network of collectively run media outlets:

www.indymedia.org/en/static/about.shtml Index on Censorship: www.indexonline.org International

Freedom of Expression Exchange: www.ifex.org

International Press Institute: www.freemedia.at/cms/ipi/

Freedom of Information Advocates network: www.foiadvocates.net/index_eng.html

Media Institute of Southern Africa: www.misa.org

One World Radio: <http://radioafrica.oneworld.net>

Panos Council – eight worldwide Panos institutes: www.panosparis.org/gb/monde.php

South Asian Free Media Association: www.southasianmedia.net

South East Europe Media Organisation: www.seemo.at

World Association of Community Radio Broadcasters: www.amarc.org

Ангилал 5. Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжихүйц хангалттай дэд бүтцийн чадавхи

А. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА ТЕХНИКИЙН НӨӨЦ БОЛОМЖТОЙ, ТҮҮНИЙ АШИГЛАЛТ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Нийгмээс тусгаарлагдсан давхаргын мэдээллийн хэрэгцээг хангах нь тухайн оронд дэд бүтэц, техникийн дэмжлэгийн олон талт хэлбэр шаарддаг. Эдгээрт үр ашигтай мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх боломжоор хангагч тоон хэвлэл мэдээллийн технологи, бүтээмжийн тоног төхөөрөмж, хиймэл дагуулын технологи буюу хараат бус хэвлэлийн үйлдвэрлэл зэрэг багтана. Мөн мэдээллээ хуурцагт бичиж, түгээдэг хүйн хэвлэл мэдээлэл зэрэг бага оврын техникийн оролцоо агуулж болно.

Хувийн хэвлэл мэдээллийн байгууллагын хэмжээнд мэдээлэл харилцааны технологийн (МХТ) хөгжил нь олон талбарт түгээлтийн тогтолцоо бий эсэх (жишээ нь, сонин хэвлэл, телевизийн онлайн хувилбар бий болгох), агуулга хадгалж архивлах чадавхи, иргэдэд хэвлэл мэдээллээр дуу хоолойгоо сонсгоход МХТ ашиглах, МХТ-г аюулгүй, найдвартай, боломжийн хэмжээгээр ашигладаг сэтгүүлчдийн хувь хэмжээ зэрэг үзүүлэлтээр шалгагддаг.

Бүхий л салбарт, аль нэгийг орхилгүйгээр хөгжлийн зохих хэмжээнд хүрсэн эсэхийг нягтлахын тулд олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээллийн МХТ ашиглалтын байдлыг хооронд нь харьцуулж болно.

Үүнээс гадна, МХТ-ийн агуулга боломжтой бөгөөд хүртээмжтэй байж боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг асуудалтай холбоотой орон нутгийн мэдээллийн хэрэгцээг хангаж, мэдээллийн ардчилсан хүртээмж, өнөө болон ирээдүй үеийнхний сургалт зэрэгт чиглэгдэх ёстой

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГА МЭДЭЭ ЦУГЛУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ, ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ БОЛОМЖТОЙ

- сэтгүүлчид баталгаатай, найдвартай, үнийн хувьд боломж бүхий мэдээлэл харилцааны технологийг хүртдэг, түүнийг үр дүнтэй ашиглахад суралцдаг
- сэтгүүлчид өргөн хүрээний лавлагаа, архивын материал ашиглах боломжтой
- хүйн хэвлэл мэдээлэл нийгмийн орхигдсон хүй олонд хүрэх боломж бүхий тоног төхөөрөмжөөр хангагддаг
- сонин хэвлэл нийтлэх, түгээхэд тохирохуйц техник, тоног төхөөрөмжөөр хангагддаг
- мэдээллийн байгууллагууд олон талбарт түгээлтийн систем ашигладаг

- **олон нийтийн, хувийн, хүйн хэвлэл мэдээлэл нь иргэдийн хэвлэл мэдээллийн хооронд харилцаа бий болгохын тулд мэдээлэл харилцааны технологи ашигладаг**

Нотлох аргууд

- онлайн сонины хувь, онлайнгаар дамжуулалт хийдэг өргөн нэвтрүүлэгчдийн тоо хэмжээ зэрэг хэвлэл мэдээлэл олон талт түгээлтийн систем ашиглалтын хэмжээ
- хэвлэл мэдээллийн техникийн хүчин чадлын талаар хандивлагч эсвэл итгэл даахуйц байгууллагын тайлан
- сэтгүүлчдийн ашиглаж буй техник, тоног төхөөрөмждөө сэтгэл хангалуун байдалд хийсэн судалгаа
- урт хугацааны нөөц сонгох шалгуур, олон нийтийн мэдээллийн хүртээмж зэрэг архивын баримт
- иргэд хэвлэл мэдээллээр дуу хоолойгоо хүргэхэд (хэлэлцүүлэг, мэтгэлцээн, блог, иргэдийн мэдээлэл, хэрэглэгчээр удирдуулсан агуулга г.м) мэдээлэл харилцааны технологи ашиглалтын баримт

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

African Media Development Initiative:

www.bbc.co.uk/worldservice/trust/specials/1552_trust_amdi/index.shtml

BBC World Service Trust: www.bbc.co.uk/worldservice/trust

Internews: www.internews.org

International Research and Exchanges Board, IREX – Media Sustainability Index, indicators relating to professional journalism: www.irex.org

UNESCO – Communication and Information Activities – capacity building:

[http://portal.unesco.org/ci/en/ev.php-](http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=19487&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

[URL_ID=19487&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html](http://portal.unesco.org/ci/en/ev.php-URL_ID=19487&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

В. СОНИН ХЭВЛЭЛ, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИ НЭВТЭРСЭН БАЙДАЛ

АГУУЛГА БА ҮНДСЭН АСУУДАЛ

Хүн амын хэчнээн хувь нь сонин хэвлэл, радио телевиз, интернэт, суурин болон гар утас хэрэглэж байгааг тодорхойлох тоон хэмжүүр байдаг. Эдгээрийг Олон улсын цахилгаан холбооны байгууллагын (ITU) Тоон боломжийн индекс (*Digital Opportunity Index*)-ын нэгдмэл хэмжигдэхүүн гаргахад ашиглаж болно.

Нийгмээс тусгаарлагдсан давхарга нь харилцааны хэлбэрүүд, тэдний хэрэглэж чадах мэдээллийн хэрэгслийг хүртэх боломжийг тодорхойлохын тулд Үндэсний өгөгдлийг бүрэлдэхүүн хэсгээр

задлах шаардлага тулгардаг. Жишээлбэл, хэвлэл мэдээллийн хүртээмж, ашиглалтын байдал эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд ямар ялгаатай байдаг вэ? Нийгмээс тусгаарлагдсан давхаргад мэдээлэл харилцааны ямар ч талбарын хүртээмжид саад тогтгор байдаг эсэх? Бичиг үсгийн боловсрол багатай ард иргэдэд сонин хэвлэлээс бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл сайн үйлчилгээ үзүүлдэг эсэх? Хэвлэл мэдээлэл, тэр дундаа интернетийн олон хэл дээр түгээх харьцангуй түвшин ямар байна вэ?

Уян хатан хандлага чухал байдаг. Нийгмээс тусгаарлагдсан ард иргэдийн мэдээ, мэдээллийн гол эх сурвалж нь радио болдог нөхцөлд түүний хамрах хүрээ тэлэх эсвэл хумигдаж байгаа эсэх? Олон нийтийн эсвэл хүйн өргөн нэвтрүүлэгчдийн нэвтрэлт бусад арилжааны хэвлэл мэдээлэлтэй харьцуулахад өсч байгаа эсвэл зогсонги байгаа эсэх?

Нийгмээс тусгаарлагдсан давхаргын хэрэгцээ шаардлагад нийцсэн үндэсний МХТ-ийн бодлогын хөгжил нэн чухал. Хот, хөдөөгийн хүн амын дунд, тэдний хооронд тоон хуваагдлыг амжилттай арилгах нэгдмэл төсөл байдаггүй. Гэсэн ч, хэвлэл мэдээллийн хөгжилд хувь нэмэр оруулагч байгууллага, олон улсын байгууллагын туршлагаар зарим ерөнхий зарчмуудыг санал болгодог.

Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төр засаг, хувийн хэвشلүүдийн хамтын хүчээр МХТ-ийн хүртэмжийг ардчилсан болгоход хэсэгчилсэн хандлагаас илүү амжилттай. Үндэсний МХТ-ийн улсдаа холбоо бүхий стратегийг хэрэгжүүлж, нийгмээс тусгаарлагдсан давхаргын хэрэгцээ шаардлагыг харгалзсан үнийн бодлого баримтлахад цахилгаан холбооны төлөөлөл, интернетийн үйлчилгээ үзүүлэгчдийн оролцоог шаардана. Мөн нийтийн зорилгыг хэрэгжүүлэх, мэргэжлийн сургалт зохион байгуулах, олон нийтийг ухуулж ойлгуулах замаар тэдний чадавхи дээшлүүлэхэд олон иргэний нийгмийн байгууллагын оролцоо шаардлагатай.

Түүнчлэн, эрх зүй, нийгмийн байгууллын шинэчлэл нь МХТ-ийн дэс дараатай зохицуулалт хийхэд чухал үүрэгтэй. Нийгмийн бүх, ялангуяа нийгмээс тусгаарлагдсан бүлгүүдэд өндөр хүчин чадал бүхий шугамыг бага үнээр хангах зорилгоор орон нутгийн нөхцөл байдалд тохирохуйц дэд бүтцийг хөгжүүлэхэд бүх сонирхогч талууд оролцох ёстой.

Ардчилсан Конго улс дахь Multi Sector ICT Dynamic (DMTIC) байгууллагын үйл ажиллагаа МХТ-ийн дутагдалыг нөхсөн тухай тэргүүн туршлагын загварын эндээс үзнэ үү: http://downloads.bbc.co.uk/worldservice/trust/pdf/AMDI/drc/amdi_drc_full_report.pdf.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.2 НИЙГМИЙН ОРХИГДСОН БҮЛГҮҮД ӨӨРСДИЙН АШИГЛАЖ ЧАДАХ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ БҮХИЙ Л ХЭЛБЭРИЙГ ХҮРТДЭГ

- олон нийтийн өргөн нэвтрүүлэг улс орон даяар нэвтрэх техникийн боломжтой
- төр засгийн зүгээс бүх өргөн нэвтрүүлэгчдэд газар зүйн хувьд аль болох өргөн хүрээ хамрах боломжоор хангахад нааштай алхмууд хэрэгжүүлдэг
- бичиг үсэгт тайлагдаагүй явдал газар авсан нутгийн иргэдэд сонин хэвлэлээс бусад

хэвлэл мэдээлэл хүртээмжтэй байдаг

- хүй олонд тулгуурласан өргөн нэвтрүүлэгч, нийтлэгчид зорилтот нутаг дэвсгэртээ өргөн хүрээнд тархсан байдаг

Нотлох аргууд

- өргөн нэвтрүүлэг, сонин хэвлэлийн хүртээмж, хэрэглээний талаарх статистикийн нарийвчилсан тоо баримт, санал асуулгын мэдээлэл
- нийгмээс тусгаарлагдсан давхаргын ашиглаж болохуйц мэдээлэл, харилцааны хэлбэрүүдэд улсын болон арилжааны хөрөнгө оруулалтын хэмжээ
- харилцааны талбар, түүнчлэн хүйн хэвлэл мэдээллийн хүртээмжийн талаар итгэл даахуйц байгууллагын тайлан

5.3 ТУХАЙН УЛС НИЙГМЭЭС ТУСГААРЛАГДСАН ДАВХАРГЫН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЦЭЭНД НИЙЦЭХИЙГ ЗОРЬСОН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИЙН ДЭС ДАРААТАЙ БОДЛОГО ЯВУУЛДАГ

- иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, төр засаг, арилжааны байгууллагууд мэдээлэл, харилцааны технологийг хүртээмжтэй байлгах асуудлаар хамтран ажилладаг
- нийгмээс тусгаарлагдсан давхаргыг үнийн бодлогоор гадуурхдаггүй
- тоон шилжилтийн бодлого, стратегитэй

Нотлох аргууд

- мэдээлэл харилцааны технологийн хүртээмж, ашиглалтын талаарх статистикийн нарийвчилсан тоо баримт, санал асуулгын мэдээлэл
- нийгмээс тусгаарлагдсан давхаргын хэрэгцээ шаардлагад нийцсэн үндэсний мэдээлэл, харилцааны технологи нэвтрүүлэхэд төрийн, хувийн, иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажилладаг тухай баримт
- үнийн бодлого, бүтцийн харьцуулсан үнэлгээ

ӨГӨГДЛИЙН ЭХ СУРВАЛЖ

African Media Development Initiative:

www.bbc.co.uk/worldservice/trust/specials/1552_trust_amdi/index.shtml

CIA World Factbook – country data on communications:

www.cia.gov/cia/publications/factbook/index.html

Globescan – global public opinion and stakeholder research: www.globescan.com

International Telecommunications Union: *ICT and Telecommunications in Least Developed Countries: mid-term review for the decade 2001–2010*: [www.itu.int/ITU - D/ ldc/pdf/ICTand%20TELinLDC-e.pdf](http://www.itu.int/ITU-D/ldc/pdf/ICTand%20TELinLDC-e.pdf)

International Telecommunications Union – *World Information Society Report 2006* (includes the *Digital Opportunity Index*): [www.itu.int/osg/spu/publications/ worldinformationsociety/2006/wisr-](http://www.itu.int/osg/spu/publications/worldinformationsociety/2006/wisr-)

summary.pdf

Media Sustainability Index www.irex.org/msi

Organisation for Economic Co-operation and Development – Measuring the Information Economy:
www.oecd.org/document/23/0,2340,en_2649_34449_33987543_1_1_1_1,00.html

Pew Research Center for the People and the Press: <http://people-press.org/>

Steadman Group (covers sub-Saharan Africa): www.steadman-group.com/research_index.php

UNESCO Institute for Statistics – Questionnaire on Newspaper Statistics:
www.uis.unesco.org/ev.php?ID=5831_201&ID2=DO_TOPIC

UNESCO Institute for Statistics – Questionnaire on Radio and Television Broadcasting
Statistics: www.uis.unesco.org/ev.php?ID=6554_201&ID2=DO_TOPIC

Wealth of Nations Triangle Index: www.ghfund.com/WNIOverview.php

World Association of Community Radio Broadcasters: www.amarc.org

World Bank: World Development Indicators – The Information Age:
<http://devdata.worldbank.org/wdi2006/contents/Section5.htm>

World Economic Forum – Global Information Technology Report:
www.weforum.org/en/initiatives/gcp/

[Global%20Information%20Technology%20Report/index.htm](http://www.weforum.org/en/initiatives/gcp/Global%20Information%20Technology%20Report/index.htm)

Data also available from National Statistical Offices and government ministries,
operators' published statistics, industry press, independent media monitoring reports
etc.